# ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
# 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**2024.12.13**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /сая.төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2024 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1.1.1.** Цусны донорын сургалт сурталчилгааг өргөжүүлж донор элсүүлэлтийг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 1 | Сайн дурын авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлнэ. | - | Цус, цусны бүрэлдэхүүн хэсэг цуглуулалтын тоо, хувь | 2023 онд нийт 32769 нэгж цус цусны бүрэлдэхүүн хэсэг цуглуулсан. | Сайн дурын авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлж 34000 донороос цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулсан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 100% хангасан байна. | 2024 онд 34000 нэгж цус цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулна гэж төлөвлөснөөс 34105 нэгж цус цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулсан байна. Гүйцэтгэл 100.3% байна. Нийт цуглуулалтын 60,1%-ийг суурин хэлбэрээр, 39,9%-ийг явуулаар цуглуулсан байна. Үүнээс:<br>• Бүхэл цус-31924 нэгж<br>• Сийвэн -1677 нэгж<br>• Ялтас эс-504 нэгж<br>Элэг шилжүүлэн суулгах болон бусад хагалгааны үед хэрэглэгдэх захиалгат бүтээгдэхүүнийг тухай бүрд нь бүрэн бэлтгэж олгосон. 2024 оны эхний 11 сарын байдлаар цитоферезинй аргаар 460 нэгж ялтаст эс цуглуулсан байна.<br>Төвийн Ерөнхий захирлын 2024 оны А/18 тоот тушаалаар 16 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилогдон Оюутолгой ХХК-ний Өмнөговь аймгийн уурхайн цогцолборт цус цуглуулах өдөрлөг зохион байгуулж 3 хоногт 576 нэгж, 2024 оны А/52 тоот тушаалаар 12 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилогдон Дархан-Уул аймгийн АШУҮИС болон ШУТИС-ийн салбар сургуулиуд дээр, цус цуглуулах өдөрлөг зохион байгуулж 3 хоногт 335 нэгж буюу нийт 911 нэгж цус цуглуулж нөөц нэмэгдүүлэх, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах дадлага сургуулилт хийсэн. | 100,8% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | 2024 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг боловсруулан бүрэн хэрэгжүүлж ажиллана. | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 2023 онд нийт 97117 нэгж ЦЦБ үйлдвэрлэсэн. | 99100 нэгжээс багагүй ЦЦБ үйлдвэрлэж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 100% хангасан байна. | Нийт 99100 нэгж ЦЦБ үйлдвэрлэхээс 106830 нэгжийг үйлдвэрлэж, төлөвлөгөөний биелэлт 108% байна.<br><br>• Даршилсан улаан эс 29120 нэгж үйлдвэрлэхээс 31945 нэгж үйлдвэрлэж биелэлт 110% байна.<br>• Сийвэнгийн бүтээгдэхүүн 38480 нэгж үйлдвэрлэхээс 39847 нэгж үйлдвэрлэж биелэлт 103%,<br>• Ялтаст эсийн өтгөрүүлэг 15602 нэгж үйлдвэрлэхээс 17335 нэгжийг үйлдвэрлэж биелэлт 111%,<br>• Угаасан улаан эс 683 нэгж үйлдвэрлэхээс 767 нэгжийг үйлдвэрлэж биелэлт 112%,<br>• Криопреципитат 4420 нэгж үйлдвэрлэхээс 4927 нэгж үйлдвэрлэж биелэлт 111% байна. | 108% |
| 3 | Сайн дурын идэвхтэн, бэлтгэх, чадавхжуулах сургалтыг хамтран зохион байгуулна. | 25.0 МУЗН-ийн санхүүжилт | Сайн дурын идэвхтэн бэлтгэх сургалтын тоо, хамрагдсан хүний тоо | 2023 онд МУЗН-тэй хамтран 3 удаагийн сургалтаар 200 хүн хамруулж, үүнээс 150 сайн дурын ажилтан чадавхжуулах сургалтад хамруулж 10 сургагч багш бэлтгэж гэрчилгээ олгосон. | 2024 онд МУЗН-тэй хамтран 3-аас доошгүй сургалт зохион байгуулж чадавхжуулсан сайн дурын ажилтан, сургагч багшийн тоо суурь үзүүлэлтээс буураагүй байна. | ЭМЯ, МУЗН, БЗД-ийн улаан загалмайн хороо, ИТХ-ын ажлын албатай хамтран 3 удаагийн сургалт зохион байгуулсан. Үүнд:<br>1. Өсвөрийн улаан загалмайчдад "Сайн дурын авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлэхэд сайн дурын ажилтны оролцоо" сэдвээр сайн дурын идэвхтэн бэлтгэх нэг өдрийн сургалт зохион байгуулж ЕБС-ийн нийт 64 сурагч хамрагдаж гэрчилгээ олгосон.<br>2. МУЗН-ийн хөгжлийн хөтөлбөр, УЗХ-ны арга зүйн төвд "Амин агшин" донор элсүүлэгч бэлтгэх 2 өдрийн сургалт 2-4, 6-8 цагийн сонгосон хөтөлбөрөөр хийж БЗД-ийн 43 хорооны хэсгийн ахлагч, тус дүүргийн 12 аж ахуйн нэгж байгууллагын эмч, нийгмийн ажилтан 55 хүн хамрагдсан.<br>3. ЭМЯ, МУЗН-тэй хамтран сайн дурын идэвхтэн, бэлтгэх, чадавхжуулах, сургагч багшийн сургалт МУЗН-ийн Анхны тусламж, нөхөн сэргээх төвд 12 дугаар сард зохион байгуулагдаж Нийслэлийн Улаан загалмайн хорооны арга зүйч, сайн дурын ажилтнууд нийт 80 хүн хамрагдсан. Энэ сургалтаар 15 сургагч багш, 65 сайн дурын идэвхтэн бэлтгэж чадавхжуулсан. **Нийт 3 удаагийн сургалтад 199 хүн** хамрагдсанаас 162 нь сайн дурын идэвхтэн, 37 нь сургагч багш болж бэлтгэгдсэн. | 100% |
| 4 | Хүн амд зориулсан амьдралын зөв дадал хэвшлийн талаар мэдээ мэдээлэл түгээнэ. | - | Шинээр бүтээсэн контентын тоо<br>Олон нийтэд хүргэсэн сургалт, | 2023 онд ЭМЯ, НЭМҮТ-өөс гаргасан 10 гаруй нэр төрлийн нугалбар, постер | Шинээр контент бүтээх буюу ЭМЯ, НЭМҮТ зэрэг бусад эх үүсвэр тодорхой баталгаажсан | Төвийн вэб сайт, 2 пейж хуудас, 1 фейсбүүк группийг тогтмол ажиллуулж ДЭМБ, ЭМЯ, НЭМҮТ зэрэг байгууллагаас гаргасан тодорхой эх үүсвэртэй мэдээллийг иргэд, цусны доноруудад хүргэдэг. Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв, Амьдрал бэлэглэе | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | , | | сурталчилгаа, мэдээллийн тоо | контентыг цахим, танхим, самбараар 112 удаагийн давтамжтай түгээсэн. шинээр 10 контент бүтээж сургалт сурталчилгаанд ашигласан. | мэдээллийг цахим орчинд байршуулж ард иргэдэд хүргэсэн байна. | пэйж хуудас, Донор та баатар групп хуудсанд нийт 132 эрүүл мэндийн зөвлөгөө, зөвлөмж, мэдээллийг давхардсан тоогоор 262 удаа байршуулан ард иргэдэд хүргэсэн. Пейж хуудасны дагагчийн тоо 53000 болж, хандалтын тоо 51.8 %-иар тус тус нэмэгдсэн. 5470 ширхэг тараах материал түгээсэн. 3280 төрийн албан хаагч, 235 сайн дурын идэвхтэн, 10182 оюутан 240 сурагчдад танхим, онлайнаар зөвлөмж мэдээлэл хүргэсэн.<br>- ДЭМБ-ын санхүүжилтээр цусны донорын донор алдаршуулалт, тэмдэглэлт өдрүүд сэдвээр 3 минутын шторк хийж нийтэд сурталчилсан.<br>- Төвийн цахим хуудсанд **“Эмч зөвлөж байна”** цэс тогтмол ажиллуулж 2024 оны байдлаар 14 нэр төрлийн зөвлөгөө мэдээллийг хүргэсэн байна.<br>- Суурин төвөөр үйлчлүүлж буй доноруудад зориулан “Сийвэн өгөхийн өмнөх хооллолтын тухай” зөвлөмж өгч, тараах материалаар зөвлөмж бэлтгэн давхардсан тоогоор 2021 сийвэнгийн донорт өгсөн.<br>- Төвийн мэдээллийн самбараар иргэд доноруудад зориулсан эрүүл мэндийн зөвлөгөө хүргэдэг. Мэдээллийг тогтмол шинэчлэн нийт 12 нэр төрлийн 56 зурагт хуудас 92 удаа байршуулсан. | |
| **Зорилт 1.1.2.** Цусны донор алдаршуулах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, үр дүнг сайжруулна | | | | | | | |
| 5 | Цусны донорын “Үндэсний өдөр”-ийг тэмдэглэнэ. | 15.5 Улсын төсөв Төрийн болон ТББ | Цусны донорын “Үндэсний өдөр”-ийг тэмдэглэсэн тайлан. | 2023 оны 1 дүгээр сарын 3-нд Цусны донорын Үндэсний өдрийг зохион байгуулж донор алдаршуулсан. | Цусны донорын “Үндэсний өдөр”-ийг тэмдэглэж, цусны донорын үйлсийг олон нийтэд сурталчлан, тэднийг алдаршуулсан байна. | Цусны донорын Үндэсний өдөр тэмдэглэх удирдамж, төсөв ерөнхий захирлын 2024 оны А/20 тушаалаар баталж хөтөлбөрийн дагуу арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээний гол зорилго нь цусны доноруудыг алдаршуулах бөгөөд МУЗН хамтран зохион байгуулсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 120 ба түүнээс дээш удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн 9 Хүндэт донорыг “Шударга журам” медалиар шагнаж баяр хүргэсэн. Мөн Алтан донор 1, Мөнгөн донор 1, Хүрэл донор 1, хамгийн олон удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн 1 донор, Бахархал 10, 20, 30, 40, 50 тэмдгээр нийт 10 донорыг шагнаж алдаршуулсан. 2023 оны “Цусны донор хамт олон”-оор Дотоодын цэргийн 805 дугаар анги, “Хүмүүнлэгийн үйлсийг дэмжигч шилдэг байгууллага”-аар БЗД-ийн ИТХ-ын ажлын алба, “Донор элсүүлэгч шилдэг байгууллага”-аар АШУҮИС-ийн Залуучуудын Улаан Загалмайн хороог шалгаруулж хамт олон, ард иргэдийн дунд алдаршуулав. МУЗН-ийн “Энэрэл” алтан медалиар 1, “Нигүүлсэл” алт, мөнгөн медалиар 2 донор, донорын үйлсийг дэмждэг иргэнийг шагнаж байнгын донорт онооны урамшууллыг нь олгосон. Мөн 35 ба түүнээс | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дээш удаа цус цусны бүрэлдэхүүн хэсгээ бэлэглэсэн 24 донорт Хүндэт донорын цол тэмдгийг гардуулж баяр хүргэв. Сошиал орчинд болон МҮОНРТ-ийн цагийн хүрд, Монголын радио, хэвлэл мэдээллийн байгууллагаар арга хэмжээний мэдээлэл, ярилцлага, мэдээг түгээсэн. Хавсралтаар тайлан. | |
| 6 | "Цусны донорын Дэлхийн өдөр"-ийг зохион байгуулна. | 15.0 Улсын төсөв ДЭМБ-ын санхүүжилт | Цусны донорын Дэлхийн өдрийг зохион байгуулсан тайлан. | 2023 оны 6 сарын 14-нд Цусны донорын Дэлхийн өдрийг Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. | ДЭМБ-ын 2024 оны удирдамжийг олон нийтэд сурталчилж, Цусны донорын Дэлхийн өдрийг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлсэн байна. | Жил бүрийн 6 сарын 14-ны өдрийг дэлхий даяар Цусны донорын өдөр болгон тэмдэглэж, өвөрмөц уриан дор цусны донорт талархал илэрхийлэх, алдаршуулах, цусны донорын үйлсийг сурталчлах арга хэмжээг зохион байгуулдаг уламжлалтай.<br>2024 оны "Цусны донорын Дэлхийн өдөр"-ийн 20 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээг **"Амьдрал бэлэглэсэн 20 жил: Цусны донор танд баярлалаа"** уриан дор БЗД-ийн Жанжин клубт зохион байгуулсан. Арга хэмжээнд Эрүүл мэндийн яамны эмнэлгийн тусламж үйлчилгээний газрын дарга, МУЗН, МДХ-ны хүндэт зочид, бусад байгууллага хамт олны төлөөлөл, хүндэт донорууд, улаан загалмайчид, ОУ-ын байгууллагын төлөөлөл оролцсон. Уламжлалын дугуу шилдэг тэргүүний байгууллага, цусны донор, хүмүүнлэгийн ажилтныг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Шударга журам медаль, төвийн болон МУЗН, хандивлагчийн шагналаар шагнаж алдаршуулсан. Шинээр хүндэт донорын болзол хангасан нийслэлийн 40 цусны донорт үнэмлэх тэмдгийг олгов. 20 гаруй хэвлэл мэдээллийн байгууллага сайт мэдээ, шууд ярилцлага хийсэн. ДЭМБ-ын санхүүжилтээр цусны донорын сурталчилгааны материал хэвлүүлж, Цусны донорын тэмдэглэлт өдрүүд, донор алдаршуулалтын талаар шторк бэлтгэн сургалт, сурталчилгаанд ашиглаж байна. Энэ үеэр Дусал цус дүүрэн амьдрал аян, Оюу толгойн уурхайн цогцолборт хийсэн Алсын явуулын цус цуглуулалтыг онцлох арга хэмжээгээр шалгаруулсан нь гамшгийн үеийн бэлэн байдлыг шалгах, нөөц бүрдүүлэхэд ач холбогдолтой арга хэмжээ байв. Азийн цус сэлбэлтийн холбооноос цусны донорын Дэлхийн өдрийн 20 жилийн ойн арга хэмжээг нийт гишүүн орнуудыг оролцуулан нээлттэйгээр шууд дамжуулахаар зохион байгуулсны дагуу Цус сэлбэлт судлалын үндэсний төв уг арга хэмжээг шууд дамжуулж бусдын хүртээл болгохын дээр бусад улс орнуудын туршлагаас суралцсан. Үндэсний хэмжээнд өөрийн пейж хуудсаараа шууд дамжуулсан. Хавсралтаар тайлан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | "Цусаа бэлэглэх өдөр"-ийг 2-12 дугаар саруудад зохион байгуулна. | 24.0 Улсын төсөв Эрүүл мэндийг дэмжих сан Төрийн болон ТББ | Цусаа бэлэглэх өдөр тэмдэглэсэн тайлан. | 2023 онд Цусаа бэлэглэх өдрийг 11 удаа зохион байгуулж цусны байнгын донор, донор хамт олныг шагнаж алдаршуулсан. | Сар бүрийн 3 "Цусаа бэлэглэх өдөр"-ийн арга хэмжээг 11 удаа зохион байгуулж цусны донор, донор хамт олон, донорын үйлсийг дэмжигч байгууллагуудыг шагнаж алдаршуулсан байна. | Сар бүрийн 3 "Цусаа бэлэглэх өдөр"-ийн арга хэмжээг 11 удаа зохион байгуулж цусны байнгын донор, донор хамт олон, донорын үйлсийг дэмжигч байгууллагуудыг шагнаж алдаршуулсан. Үүнд:<br>1. Алтан донор-3<br>2. Мөнгөн донор 13<br>3. Хүрэл донор 15<br>4. Бахархал 50 тэмдгээр 22<br>5. Бахархал 40 тэмдэгээр 32<br>6. Бахархал 30 тэмдгээр 30<br>7. Бахархал 20 тэмдгээр 36<br>8. Бахархал 10 тэмдгээр 57<br>Үйл ажиллагааг Наран фүүдс, БЗД-ийн ЗДТГ, ИТХ-ын Ажлын алба, УЗДШХ, МУЗН, Наран фүүдс Ulker Mongolia, Үнэртэй усанд дурлагсдын клуб, Улаанбаатар Смарт карт ХХК, МДХ ТББ, Улаан загалмайн Хүүхэд Залуучуудын Хөдөлгөөн зэрэг байгууллагууд дэмжин хамтран зохион байгуулж, цусны байнгын доноруудыг шагнаж алдаршуулсан. Сар бүрийн 3 цусаа бэлэглэх өдрөөр иргэд, байгууллага хамт олны төлөөлөл нийт 1738 донор цусаа бэлэглэж хүмүүнлэгийн үйл ажиллагаанд нэгдсэн. Энэ өдөр цусаа бэлэглэсэн хүндэт донор, тогтмол хугацаанд цусаа өгдөг байнгын доноруудын алдаршуулалтын мэдээллийг Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Амьдрал бэлэглэе пейж хуудас Донор та баатар фейсбүүк группэд байршуулж нийтэд сурталчлан алдаршуулсан. Телевиз, хэвлэл мэдээллийн байгууллагаар байгууллагын удирдлага, хүндэт донорууд ярилцлага өгч цусны донорын сурталчилгаа мэдээллийг олон нийтэд хүргэсэн. | 100% |
| **Зорилт 1.1.3.** Цусны донорын эрүүл мэндэд учирч болзошгүй хүндрэл, сөрөг нөлөөллөөс сэргийлэх үзлэг, шинжилгээ хийнэ. | | | | | | | |
| 8 | Цусны донорт ферритин тодорхойлж донорт илрэх сөрөг хариу урвалаас сэргийлнэ. | 57.3 Улсын төсөв | Ферритин тодорхойлох шинжилгээнд хамрагдсан донорын тоо | 2023 онд 1012 байнгын донорт ферритин тодорхойлох шинжилгээ хийж цус багадалтыг тодорхойлсон. | 1000-с доошгүй донорт ферритин тодорхойлж, шинжилгээний хариуд дүгнэлт хийсэн байна. | Цусны донорын эрүүл мэндийг хянах, сөрөг урвал хүндрэлээс сэргийлэх зорилгоор тогтмол хугацаанд цусаа өгсөн 1082 донорт ферритин тодорхойлох шинжилгээ хийсэн. Шинжилгээнд хамрагдсан доноруудын 705 буюу 65,2%-д нь ферритиний хэмжээ хэвийн, 23 буюу 2,1%-д ферритиний хэмжээ ихэссэн, 354 буюу 32,7%-д нь багассан үзүүлэлттэй байна. Хэвийн хэмжээнээс багассан үзүүлэлттэй доноруудад ДЭМБ-ын зөвлөмж болон олон улсад хэрэгжүүлж буй заавар зөвлөмжийг үндэслэн 6-12 сарын хугацаанд цусаа өгөх хугацааг түр хойшлуулах арга хэмжээ авч ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Хөдөлгөөнт хэлбэрээр цус цуглуулах үйл ажиллагаанд зориулалтын ор ашиглаж донорт илрэх сөрөг хариу урвалаас сэргийлнэ. | - | Зориулалтын ор ашигласан хувь | 2023 онд явуулын хэлбэрээр цус цуглуулах үйл ажиллагааны 55.5%-д зориулалтын ор ашигласан. | Явуулын хэлбэрээр цус цуглуулалтын 60%-д зориулалтын ор ашигласан байна. | 2024 оны 12 сарын 10-ны байдлаар 93 удаагийн явуулын хэлбэрээр цус цуглуулах үйл ажиллагаанд зориулалтын зөөврийн орыг хэрэглэж 7846 донороос цус цуглуулсан байна. Энэ хугацааны нийт цус цуглуулалт 13063 нэгж бөгөөд зориулалтын ор ашиглалт 60%-ийг эзэлж байна. Зөөврийн орыг хэрэглэснээр донорт тав тухтай орчныг бүрдүүлж, донорын аюулгүй байдал, цус өгсний дараах хариу урвалаас сэргийлэх ач холбогдолтой бөгөөд ор ашигласан цуглуулалтад сөрөг хариу урвал гараагүй болно. | 100% |
| 10 | Цусны доноруудад Анти-А болон Анти-В эсрэг биеийн титр тодорхойлох шинжилгээг нэвтрүүлнэ. | - | Батлагдсан САЗ, Анти-А болон Анти-В эсрэг биеийн титр тодорхойлсон тоо | Монгол хүний Анти-А болон Анти-В эсрэг биеийн титрийн тодорхойлох шинжилгээ хийгдээгүй. | Батлагдсан стандарт ажиллагааны зааврын дагуу 3000-аас доошгүй цусны донорт Монгол хүний Анти-А болон Анти-В эсрэг биеийн титрийн тодорхойлсон байна. | Цусны анти-А, В эсрэгбиеийн титрийг хуруу шилний аргаар тодорхойлох шинжилгээний САЗ-НЛ-3-ИГ-14-01-ийг боловсруулан батлуулж, нийт 3000 донорт титр тодорхойлох шинжилгээг хийгээд байна.<br>Эсрэгбиеийн титрийн түвшин нь биеийн жингийн индекстэй хамааралтай байсан ба ялангуяа илүүдэл жинтэй болон таргалалттай хүмүүсийн дунд эсрэгбиеийн титрийн түвшин илүү өндөр (1:32<) байсан. Хүйсийн хувьд эрэгтэйчүүдийн дунд анти-А эсрэгбиеийн титр өндөр байсан бол харин эмэгтэйчүүдийн дунд анти-А болон анти-В эсрэгбиеийн титр хоёулаа өндөр (1:32<) түвшинтэй тодорхойлогдсон. | 100% |
| 11 | Цусны доноруудын резусын дэд бүлгийг тодорхойлж, цахим мэдээллийн санг баяжуулна. | | Резусын дэд бүлгийг тодорхойлсон тоо, цахим программд оруулсан донорын тоо | 2023 оноос зөвхөн элэг шилжүүлэн суулгах хагалгаанд олгодог бүтээгдэхүүний резусын дэд бүлгийг тодорхойлж донор инфо үндсэн үйл ажиллагааны программд мэдээллийг оруулж 1500 цусны донорын мэдээллийн сан үүсгэсэн. | Цусны донорын резусын дэд бүлгийг тодорхойлж цахим программд оруулан мэдээллийн санг баяжуулж, шаардлагатай тохиолдолд мэдээллийг цахим сангаас хайх нөхцөлийг бүрдүүлсэн байна. | 4070 цусны донорын резусын дэд бүлгийг тодорхойлж цахим программд оруулан мэдээллийн санг үүсгэсэн. Шаардлагатай тохиолдолд уг мэдээллийг цахим сангаас хайх нөхцөлийг бүрдүүлсэн. | 100% |
| 12 | “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын Дэлхийн өдөр”-ийг тэмдэглэнэ. | - | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын өдрийн удирдамж, тайлан | 2023 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийг “Үйлчлүүлэгчийн дуу хоолойг сонсъё” уриатайгаар | Батлагдсан уриан дор “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын өдөр”-ийг тэмдэглэж, нэг сарын аян зохион | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын Дэлхийн өдөр”-ийн хүрээнд 1 сарын аян зохион байгуулж дараах ажлуудыг хэрэгжүүлсэн.Үүнд:<br>1. ДЭМБ-аас гаргасан “Оношилгоог зөв, аюулгүй хийе”, “Оношилгооны үе шатууд”, “Оношилгоог сайжруулах алхмууд”, “Хэрэв...” видео контентуудыг төвийн ажиллагсдын дотоод группт байршуулж эмч, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төвийн хэмжээнд тэмдэглэсэн. | байгуулж ажилласан байна. | эмнэлгийн мэргэжилтнийг мэдээллээр тогтмол хангаж ажилласан. Төвийн мэдээллийн самбарт эмийн зохистой хэрэглээний талаарх болон бусад үйлчлүүлэгчдэд чиглэсэн мэдээллүүдийг тогтмол байршуулж төвөөр үйлчлүүлж буй 500 гаруй үйлчлүүлэгч доноруудад хүргэсэн.<br>2. 2024 оны 09 сарын 11-нд "Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023" стандартаар төвийн нийт 40 (61.5%) ажилтанд сургалт зохион байгуулсан<br>3. Төвийн үндсэн үйл ажиллагааны тасаг болох Донор зохион байгуулалт, Үйлдвэрийн тасаг, Нэгдсэн лабораторийн тасгийн 18 сувилагч, лаборант нарт "Гардан үйлдлийг зөв хийе" ажлын байрны сургалтыг зохион байгуулж, ижил мэргэжилтний үнэлгээний хуудсаар үнэлгээ хийж зөвлөмж өгсөн.<br>4. Төвийн нэгдсэн лабораторийн тасгаас лавлагаа шинжилгээ өгч буй үйлчлүүлэгч болон эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдад чиглэсэн мэдээлэл болон цус сэлбэлт судлалын мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж буй оюутнуудад чиглэсэн цусны бүлэг, хувийн тохироо тодорхойлох ведио хичээл бэлтгэн цус сэлбэлтийн үеийн оношилгоог сайжруулах чиглэлээр үр дүнтэй ажлууд зохион байгуулсан. | |
| 13 | Цусны донорын тохойн нугалаас халдваргүйжүүлэх нэг удаагийн хэрэглээнд шилжинэ. | Улсын төсөв | Судалгааны тайлан, үр дүнгийн үнэлгээ. | Өмнө жилүүдэд цусны донорын тохойн нугалаасны халдваргүйжилтэд ариутгасан пакеттай хөвөн, арьс салст халдваргүйжүүлэх уусмал хэрэглэж байна. | Олон улсад хэрэглэгддэг нэг удаагийн хөвөн бамбарыг тогтмол хэрэглэхийн давуу болон сул тал, зардалд судалгааг хийж, үр дүнг үнэлнэ. | Цусны донорын тохойн нугалаас халдваргүйжүүлэх нэг удаагийн иодтой бамбар, наалтыг хэрэглээнд нэвтрүүлэхээр судалгаа хийсэн. Цусны донорын тохойн нугалаас халдваргүйжүүлэхэд хэрэглэх нэг удаагийн хэрэглээний материал нь халдваргүйтгэлийн бодисын улсын бүртгэлд орсон, мэс заслын талбайн халдваргүйтгэлтэй адил үйлдэлтэй (70% эсвэл 96%-ийн этилийн спирт, 5% иодын уусмалаар 2 удаа халдваргүйтгэл хийх), ЭМ-ийн сайдын А/537 дугаар тушаалаар арьсны талбайн халдваргүйжүүлэлтэд аль болох нэг удаагийн савлагаатай антисептик уусмал бүхий ариун самбай байх гэсэн шаардлагуудыг хангаж байгаа болон төвийн үйл ажиллагааны онцлогийг харгалзаж үзсэн. Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх 6 байгууллагад мэдээллийг хүргүүлж 3 байгууллага дээж ирүүлсэн. Үүнд:<br>А. Багц 1 **үнэ-4700 төгрөг**<br>- Иодтой хөвөн бамбар 1 пакет-2ш /Солонгос/<br>- Alcohol pads 70%<br>- Пластырь наалт дугуй хэлбэртэй<br>В. **Багц 2 үнэ-3000 төгрөг** | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Иодтой хөвөн бамбар 1пакет-2ш /Солонгос/<br>- Спиртны агууламжтай 1 пакет-2ш/Солонгос/<br>C. **Багц 3 үнэ-1500 төгрөг**<br>- Жгут-1ш<br>- Пластыр наалт дөрвөлжин хэлбэртэй/зүүний ором дээр наах/ -1ш<br>- Зүү тогтоох пластыр-1ш<br>- Спирттэй бамбар 1пакет-2ш жижиг<br>- Тамидинтай бамбар1пакет-2ш жижиг<br>- Жижиг 1 удаа дэвсгэр-1ш<br>Ирсэн багцуудыг хэрэглээнд туршиж, Цусны чанар аюулгүй байдлын албаны хурлаар хэлэлцэж цусны донорын тохойн нугалаасны халдваргүйжүүлэлтэд 2025 оны эхнээс нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн. Нэг удаагийн багцыг хэрэглэснээр тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал хангагдаж, цусны донор, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ. | |
| 14 | Цус цуглуулах суурин төвүүдэд анх удаа цусаа өгч буй донороос цус цуглуулах хэсгийг үе шаттай нэвтрүүлнэ. | | Шинэ донороос байнгын донорт шилжсэн тоо | 2023 онд 1081 шинэ донор хоёр буюу түүнээс дээш удаа цусаа өгч байнгын донорт шилжсэн. | Баянзүрх цус цуглуулах төвд анх удаа цусаа өгч буй шинэ донороос цус цуглуулах хэсгийг тусгайлан бий болгож донорт үзүүлэх үйлчилгээг сайжруулан байнгын донорын тоог нэмэгдүүлсэн байна. | Цус цуглуулах суурин төвүүдэд анх удаа цусаа өгч буй шинэ донорт тав тухтай орчин бүрдүүлэх, цус өгсний дараа илрэх сөрөг хариу урвалаас сэргийлэх, айдас үүсгэхгүй байх зорилгоор 2024 оны 01 сараас эхлэн цусаа бэлэглэхээр ирсэн шинэ donoruudад зөвлөгөө өгөх, ярилцах, донорын сандал дээр нь хэвтүүлэн цус авах, цус өгсний дараа 15 минут хэвтүүлэн донорт илрэх сөрөг хариу урвалаас сэргийлэх ажлыг онцгой анхаарч хэрэгжүүлсэн.Ингэснээр тайлант хугацаанд 2248 шинэ донор хоёр ба түүнээс дээш удаа цусаа өгч байнгын донорт шилжсэн байна. Баянзүрх цус цуглуулах төвд шинэ донороос цус цуглуулах хэсгийг шинээр тохижуулж донорын сандал болон бусад тоног төхөөрөмжийн худалдан авч шинээр цусаа өгч буй донорт үйлчлэх орчныг бүрдүүлсэн. | 100% |
| **Зорилт 1.2.1.** Цахим мэдээллийн сан бүрдүүлж, аюулгүй байдлыг хангана. | | | | | | | |
| 15 | “Цусны донор” аппликейшны хөгжүүлэлт хийнэ. | 8.0 Улсын төсөв | Ажлын даалгавар, хийсэн ажлын тайлан, хэрэглэгчийн өсөлтийн хувь | “Цусны донор” аппликейшныг 2022 онд шинээр ашиглаж эхэлсэн. | Ажлын даалгаврын дагуу хөгжүүлэлт хийж “Цусны донор” аппликейшн ашиглаж байгаа хэрэглэгчдийн тоог 20 хувиар нэмэгдүүлсэн байна. | Цусны Донор аппликейшн нь хэрэглэгчдэд дараагийн цус өгөх хугацаа, цусны бүлэг, нийт цус өгөлтийн тоо, цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээний хариу, дараагийн цус өгөлтийн хугацаа зэрэг мэдээллүүдийг хурдан авах боломжийг олгодог. 2024 онд дараах байдлаар хөгжүүлэлт хийгдэж байна.<br>- Гадны төлбөртэй серверт байршиж байсан Цусны донор аппликейшныг төвийн серверт байршуулж, жилд төлдөг 2 сая орчим төгрөгийг хэмнэсэн.<br>- 2022 оноос системийн шинэчлэл хийгдээгүй байсныг шинэчлэн сүүлийн үеийн IOS, android | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлдлийн системд ажиллах боломж бүрдүүлсэн.<br>- Явуулын хэлбэрээр цус цуглуулах төлөвлөгөө, байгууллагын нэр, байршил, цус цуглуулах цагийн хуваарийг харах боломжийг олгосон.<br>- Цусаар дамжих халдварын шинжилгээний хариу эерэг гарсан тохиолдолд Баянзүрх төв дээр өөрийн биеэр очиж шинжилгээний хариуг авна уу гэсэн мэдээлэл гаргадаг болгосон. Аппликейшн хэрэглэгчийн тоо 24 хувиар нэмэгдсэн. | |
| 16 | ЦССҮТ-ийн дотоод сүлжээнд "Active directory, domain controller" нэгдсэн системийг нэвтрүүлнэ. | 8.0 Улсын төсөв | Нэвтрүүлсэн нэгдсэн систем | Одоогийн байдлаар Local хаягуудаар ашигладаг. | Төвийн дотоод сүлжээнд ашиглаж буй нийт 50 компьютерыг "Active directory, domain controller" нэгдсэн системд холбож, дотоод сүлжээний аюулгүй байдлыг хангасан байна. | ЦССҮТ-ийн үйл ажиллагаанд "Active directory, domain controller" нэгдсэн системийг нэвтрүүлсэн. Ажилтан тус бүрийн компьютерт байсан албаны файлуудыг нэгдсэн нэг мэдээллийн баазтай болгож шинэчилсэн. Ингэснээр ажилтны компьютер эвдрэх, солих зэрэг эрсдэл гарахад нэгдсэн мэдээллийн баазаас хувь ажилтны эрхээр хандаж мэдээллээ авах боломж бүрдүүлсэн. Мөн ажиллагсад мэдээллийн аюулгүй байдлын ажилтны зөвшөөрөлгүй өөрсдийн дураар үл таних программ хангамж суулгах болон ашиглах боломжгүй төвлөрсөн удирдлагын хяналттай болгосон. Ингэснээр гадны халдлагад өртөх, хэрэглэгчээс үүдэлтэй мэдээлэл алдагдах эрсдэлийг бууруулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан. Нэгдсэн системийг нэвтрүүлэхэд 14 сая төгрөгийн тоног төхөөрөмж, сэлбэг худалдан авсан. | 100% |
| 17 | Төвийн номын сангийн ном сурах бичиг, сургалтын материал, сэтгүүлийн жагсаалтыг цахим хэлбэрээр бүртгэлжүүлж, сургалтын орчныг сайжруулна. | - | Цахим бүртгэлжүүлэлтийн нийт тоо, сургалтын орчныг сайжруулсан ажлын тайлан | Бүртгэл цахимжаагүй. | Төвийн номын санд байгаа нийт ном сурах бичиг, сургалтын материалын жагсаалтыг 100 хувь цахим хэлбэрт оруулсан байна. Сургалтын орчин сайжирсан байна. | Төвийн номын сангийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор номын сангийн ном, сурах бичиг, сургалтын материал болон сэтгүүлийн жагсаалтыг **nomiinsan.space** цахим хуудсанд байршуулсан ба ЦССҮТ-ийн веб хуудсанд линкийг холбон цахим номын сан үүсгэсэн. Ажиллагсад цахим номын сангаас өөрийн хайсан ном, сэтгүүл, судалгааны бүтээл зэрэг мэдээллийг цаг алдалгүй хялбар, шуурхай авах нөхцөлийг бүрдүүлсэн. Цахим номын санд нийт 358 ном, 152 сэтгүүлийн мэдээлэл багтсан. Одоогийн байдлаар төвийн 32 ажилтан бүртгүүлж үйлчилгээ авсан байна.<br>Цахим сургалтын өрөөг шилжүүлэн засвар хийж, 11,5 сая төгрөгийн үнэ бүхий дуу өсгөгч 2ш, фульт 1ш, утастай мекрофон 2ш, утасгүй мекрофон 2ш-ийг суурилуулан сургалт явуулах таатай орчныг бүрдүүлсэн. | 100% |
| 18 | Үндсэн үйл ажиллагааны программд үйлчлүүлэгчийн | - | Нэвтрүүлсэн дотоод вэб сайт | Үйлчлүүлэгчдийн хувийн мэдээлэл зөрүүтэй байдлаас | Дотоод цахим сайтыг шинээр нэвтрүүлж, хувь хүний мэдээллийн | Бүртгэлийн ажилтан үндсэн үйл ажиллагааны программд донор үйлчлүүлэгчийн хувийн мэдээллийг нэг удаа бүртгэж мэдээллийн бааз үүсгэдэг. Үйлчлүүлэгч мэдээллээ зөв оруулж буй | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийг баталгаажуулах дотоод цахим сайтыг шинээр нэвтрүүлнэ. | | | үүдэж санал гомдол ирдэг. | үнэн зөв байдал хангагдан, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж дээшилж гомдол санал буурсан байна. | эсэхэд хяналт тавих боломжгүй учраас хувийн мэдээлэл алдаатай орох, үүнээс шалтгаалан мэйлээр шинжилгээний хариу очихгүй байх зэрэг гомдол санал гардаг. Энэ байдлыг шийдвэрлэх зорилгоор бүртгэлийн ажилтны оруулж буй хувийн мэдээллийг донор, үйлчлүүлэгчид шууд харуулах үйлдэлтэй дотоод сайт болон оффлайн горимд ажиллах сайтыг хөгжүүлсэн. Цус цуглуулах суурин төвүүд болон явуулын хэлбэрээр цус цуглуулах үйлчилгээнд нэвтрүүлэн ажиллаж байна. Ингэснээр 2023 онд дээрх үйл ажиллагаатай холбоотой 1736 дуудлага утсаар ирж байсан бол 2024 онд 988 болж буурсан байна. | |
| 19 | Цусны донорын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн ажиллах журам боловсруулна. | - | Батлагдсан журам | Цусны донорын нэгдсэн бүртгэл мэдээллийн санг зохицуулсан журам байхгүй. | Цусны донорын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн ажиллах журам боловсруулж батлуулсан байна. | Донорын тухай хуулийн 7.1.7 дэх заалтыг үндэслэн "Цусны донорын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан байгуулах, сангийн ажиллах журам"-ын төслийг шинээр боловсруулсан. Төслийг боловсруулахдаа төвийн алба, тасгаас санал авч нэгтгэн удирдлагын зөвлөлөөр нийт 3 удаа хэлэлцүүлж сайжруулалтууд хийгдэн эцсийн хувилбарыг ЭМЯ-д албан бичгээр хүргүүлсэн. | 100% |
| **Зорилт 1.3.1. Л**абораторийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 20 | Цуглуулсан цусны нэгж бүрд цусны бүлэг тодорхойлж, цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээ хийнэ. | 2 370.1 Улсын төсөв | ABO, Резус, Келл бүлэг тодорхойлсон хувь, Гепатит B, C, ХДХВ тэмбүүгүйн халдвар илрүүлэх шинжилгээ хийсэн хувь | 2023 онд цуглуулсан 32769 нэгж цусанд цус сэлбэлтээр дамжих 4 халдвар болон ABO, Резус, Келл бүлгийг 100% тодорхойлж, баталгаажуулсан. | ДЭМБ-ийн зөвлөмж, шинжилгээний зураглал (алгоритм)-ыг баримтлан, цуглуулсан цусны нэгж бүрд цус сэлбэлтээр дамжих 4 халдвар болон ABO, Резус, Келл бүлэг тодорхойлох шинжилгээг 100% хийсэн байна. | ДЭМБ-ийн зөвлөмж, шинжилгээний зураглал (алгоритм)-ыг баримтлан 2024 онд цуглуулсан 34105 нэгж цус, цусны бүрэлдэхүүн хэсэг бүрд цус сэлбэлтээр дамжих 4 халдвар болон ABO, Резус, Келл бүлэг тодорхойлох шинжилгээг тус бүр 100% хийсэн. | 100% |
| 21 | Молекул биологи, иммунологи, иммуногематологи, чиглэлээр олон улсын чанарын гадаад үнэлгээнд хамрагдана. | 16.0 Улсын төсөв | Шинжилгээний чиглэл тус бүрээр чанарын гадаад үнэлгээнд хамрагдсан дүн, баталгаажилтын гэрчилгээ | 2023 онд иммуногематологи, Молекул биологи, иммунологийн чиглэлээр ОУ-ын чанарын гадаад үнэлгээнд тус бүр 1 удаа хамрагдсан. | Молекул биологи, иммунологи, иммуногематологийн чиглэлээр гадаад үнэлгээнд тус бүр 1-ээс доошгүй удаа хамрагдаж лабораторийн шинжилгээний чанарын баталгааг хангасан байна. | Молекул биологийн шинжилгээгээр Австралийн NRL лавлагаа лабораторийн чанарын гадаад үнэлгээнд<br>2024.05.01-нд 100%<br>2024.07.03-нд 100%<br>2024.10.17-нд үр дүн гараагүй<br>Иммуногематологийн шинжилгээгээр Австралийн RCPA-QAP үнэлгээнд:<br>2024.04.03-91,8%<br>2024.06.19-100.0%<br>2024.08.21-95.1%<br>2024.10.16-100% үр дүнтэйгээр нийт 4 удаа хамрагдсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Иммунологийн шинжилгээгээр хепатитын В, С вирус, ХДХВ, тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээгээр тус бүр 2 сорьцод ELISA, HISCL аппаратаар /шинжилгээний 2 өөр аргаар/<br>2024.02.07<br>2024.03.06<br>2024.04.04<br>2024.08.07<br>2024.09.04<br>2024.10.09<br>саруудад үр дүнг илгээж оролцсон. Бүх үр дүн 100% тохирсон. | |
| 22 | Гематологи, биохими, бүлэгнэлт, нян судлалын чиглэлээр үндэсний чанарын гадаад үнэлгээнд хамрагдана. | 225.0 Улсын төсөв | Шинжилгээний чиглэл тус бүрээр чанарын гадаад үнэлгээнд хамрагдсан дүн, баталгаажилтын гэрчилгээ | 2023 онд Гематологи, биохими, бүлэгнэлт, нян судлалын чиглэлээр чанарын гадаад үнэлгээнд тус бүр 1-ээс дээш удаа хамрагдсан. | Гематологи, биохими, нян судлалын шинжилгээний чиглэлээр тус бүр 1-ээс доошгүй удаа чанарын гадаад үнэлгээнд хамрагдаж лабораторийн шинжилгээний чанарын баталгааг хангасан байна. | Бүлэгнэлтийн шинжилгээний 6 дах удаагийн үнэлгээнд 4 үзүүлэлтээр харьцангуй үнэлгээ 100% үр дүнтэй оролцсон.<br>2024.05.22-нд MEQAS-аас зохион байгуулсан биохимийн 26 дах удаагийн үнэлгээнд 2 үзүүлэлтээр үнэмлэхүй үнэлгээ-93,3% харьцангуй үнэлгээ-100%<br>2024.05.22-нд MEQAS-аас зохион байгуулсан гематологийн 32 дах удаагийн үнэлгээнд 8 үзүүлэлтээр А, В үнэлгээтэй үнэмлэхүй үнэлгээ 85,00%-тай тус тус хамрагдсан.<br>2024 оны 12 сарын 3-нд биохимийн 27, гематологийн 32, бүлэгнэлтийн 7 дах удаагийн хяналтын сорьцыг шинжилж хариуг илгээсэн. Үр дүн, дүгнэлт гараагүй байна. Баталгаажилтын гэрчилгээ авсан. | 100% |
| 23 | Лабораторийн лавлагаа тусламж үйлчилгээний талаар мэдээлэл бэлтгэн үйлчлүүлэгчдэд хүргэнэ. | | Бэлтгэсэн мэдээллийн тоо, мэдээлэл авсан үйлчлүүлэгчийн тоо, сэтгэл ханамжийн судалгааны үр дүн | Веб сайт дээр товч мэдээлэл тавигдсан. | Лавлагаа тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг олон талт хэлбэрээр бэлтгэн түгээж, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлсэн байна. | -Лавлагаа шинжилгээ хийлгэж буй ард иргэд болон эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан 2 төрлийн мэдээллийг бэлтгэж, байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан.<br>-2024.04.27-нд лабораторийн 7 хоногийн үйл ажиллагааны хүрээнд нийт 80 эмнэлгийн лабораторийн мэргэжилтнүүдэд лавлагаа тусламж үйлчилгээний талаарх бэлтгэсэн мэдээллийг танхимаар хүргэсэн.<br>-2024.09.26-нд чанарын гадаад үнэлгээний тайлан семинарыг зохион байгуулж, нийт 178 лабораторийн эмч мэргэжилтнийг хамруулж, цусны бүлэг хувийн тохирооны үнэлгээний үр дүн, лавлагаа тусламж үйлчилгээний талаарх бэлтгэсэн мэдээллийг танхимаар хүргэсэн.<br>-2024.11 сард чанарын өдөрлөгөөр эмнэлгийн мэргэжилтнүүдэд лавлагаа шинжилгээний сорьц цуглуулах тээвэрлэх, шинжилгээний үр дүнг хүлээн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | авах талаарх мэдээллийг 86 эмч, эмнэлгийн ажиллагсдад танхимын хэлбэрээр тус тус хүргэсэн. 2 төрлийн мэдээллийг нийт 344 үйлчлүүлэгчид хүргэсэн. Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн 98% байна. хавсралт | |
| **Зорилт 1.4.1.** Технологи шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 100%-д хүргэнэ. | | | | | | | |
| 24 | Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлэн хөлдөөсөн шинэ сийвэн, ялтаст эсийн өтгөрүүлэгчийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | 597,4 Улсын төсөв | Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ (өсөлтийн хувь) | 2023 онд байдлаар 3100 нэгж эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлэн хөлдөөсөн шинэ сийвэн, 165 нэгж эмгэг төрүүлэгчийг идэвхгүйжүүлэн ялтаст эсийн өтгөрүүлэг үйлдвэрлэсэн. | Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлэн хөлдөөсөн шинэ сийвэнгийн 3300 нэгж, эмгэг төрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг 300 нэгжийг үйлдвэрлэж эмнэлэгт олгосон байна. | Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн бүтээгдэхүүн нийт 3600 нэгжийг үйлдвэрлэхээс 2985 нэгж үйлдвэрлэж биелэлт 82% байна. Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлэн хөлдөөсөн шинэ сийвэнгийн 3300 нэгжийг үйлдвэрлэхээс 2719 үйлдвэрлэж төлөвлөгөөний биелэлт 81%, эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг 300 нэгжийг үйлдвэрлэхээс 266 нэгж үйлдвэрлэж төлөвлөгөөний биелэлт 87% байна. Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлэх аппарат 2024 оны 8-10 сарын хооронд эвдэрсэн, ээс ялтасны нөөц багассантай холбоотой төлөвлөгөөний биелэлт буурсан байна. | 82% |
| 25 | Цагаан эсгүйжүүлсэн улаан эсийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | 119,8 Улсын төсөв | Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ (өсөлтийн хувь) | 2023 оны 12 сарын 15-ны байдлаар 15% буюу 4770 нэгж цагаан эсгүйжүүлсэн улаан эсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн. | 5200 нэгж цагаан эсгүйжүүлсэн улаан эсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн байна. | Нийт 4970 нэгжийг үйлдвэрлэхээс 5562 нэгж Цагаан эсгүйжүүлсэн улаан эс үйлдвэрлэсэн ба төлөвлөгөөний биелэлт 112% байна. | 112% |
| **Зорилт1. 4.2.** Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хадгалалт, олголтод технологийн шинэчлэл хийнэ. | | | | | | | |
| 26 | Цус бүлэгнэлтийн эмгэг, гемофили өвчний генийн эмчилгээний хамтарсан төслийн эхний үе шатыг хэрэгжүүлнэ. | 24.0<br>2024 онд ЦССҮТ-ийн зарцуулах төсөв | Шинэчилсэн мэдээллийн сан, факторын тодорхойлсон түвшин болон урьдчилан сэргийлэх тунгийн хэмжээ, хэвлэгдсэн илтгэл, төслийн тайлан | АШУҮИС, Японы Жичигийн Их Сургуультай хамтран уг төслийг 2024-2029 онд хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдсэн. | Гемофилийн эмгэгтэй хүмүүсийн мэдээллийн санг шинэчилсэн байна. VIII, IX факторын түвшин болон урьдчилан сэргийлэх тунг тодорхойлсон байна. Эрдэм шинжилгээний гадаад, дотоод илтгэл хэвлэгдсэн байна. | Цус бүлэгнэлтийн эмгэг, гемофили өвчний генийн эмчилгээний хамтарсан төслийн эхний шатны хүрээнд ЦССҮТ-д бүртгэлтэй цус бүлэгнэлтийн эмгэгтэй эмчлүүлэгчдийн сүүлийн 3 жилийн фактор хэрэглэсэн тоон үзүүлэлтээс урьдчилан сэргийлэх хэрэглээний тунгийн дундаж хэмжээг VIII, IX фактор тус бүр дээр кг/ОУН-ээр тооцон гаргаж цус бүлэгнэлтийн факторын сүүлийн 3 жилийн дундаж хэрэглээ, эдийн засгийн хэрэгцээ шаардлагын талаарх судалгааны үр дүнг АШУҮИС-ийн багт хүлээлгэн өгсөн. Энэхүү суурь судалгааг судалгааны баг 2024 оны 06 дугаар сарын 22-26-ны өдрүүдэд болсон ISTH 2024 (International Society on Thrombosis and Haemostasis) олон улсын хурал "Hemophilia: Care and Factor usage in Mongolia" сэдвээр ханын илтгэл хэлэлцүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 27 | Эмнэлгүүдийн цус цусан бүтээгдэхүүний тээвэрлэлтэд нисгэгчгүй нисэх төхөөрөмж ашиглах технологийг нутагшуулна. | Төсөл | Нисгэгчгүй нисэх төхөөрөмж ашиглаж тээвэрлэсэн ЦЦБ, эрүүл мэндийн байгууллагын тоо | AirTruck тусгай ложистикийн дроноор 12 нэгж цус цусан бүтээгдэхүүнийг цагт 36 км хурдтай 12 минутад зорилтод газраа хүргэх туршилт хийсэн. | AirTruck тусгай ложистикийн дроны хөгжүүлэлтийг хийж, 3-4 эрүүл мэндийн байгууллага руу дроноор ЦЦБ-ий тээвэрлэлтийг хийсэн байна. | Яаралтай үед эмнэлгүүдийн цус, цусан бүтээгдэхүүний тээвэрлэлтэд нисгэгчгүй нисэх төхөөрөмжийг ашиглах, нэвтрүүлэх зорилгоор Япон улсын Ньюком групптэй 3 удаагийн уулзалт хийж сонгогдсон 3 эмнэлэгт дроноор 5 төрлийн 140 нэгж цус, цусан бүтээгдэхүүн (38,259 мл)-ийг 50 удаагийн нислэгээр хүргэсэн.<br>Нэг талдаа нислэгийн дундаж хугацааг тооцоход:<br>• Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс-АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэг-Цус сэлбэлт судлалын үндэсний төв маршрутын дагуу 11 минут.<br>• Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс – Амгалан амаржих төрөлжсөн мэргэжлийн төв - Цус сэлбэлт судлалын үндэсний төв маршрутын дагуу 6 минут.<br>• Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс-ЭХЭМҮТ-Цус сэлбэлт судлалын үндэсний төв маршрутын дагуу 9 минут.<br>Дээрх нислэгийг хийхэд иргэний нисэхийн ерөнхий газраас зөвшөөрөл авч, туршилтын нислэгүүдийг амжилттай хийсэн. Ингэсээр хотын түгжрэл, цаг хугацаа, түлш шатахуун зарцуулалт, эмнэлгийн ажилтны ажлын бүтээмж нэмэгдэх зэрэг олон талын ач холбогдолтой. | 100% |
| **Зорилт 1.5.1.** Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн ЦЦБ-ий нөөц хангамж, бэлэн байдлыг хангана. | | | | | | | |
| 28 | Төвийн гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангийн 2024 оны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллана. | - | Тодотгол хийсэн төлөвлөгөө, тайлан | 2023 онд Төвийн гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөөг шинэчлэн БЗД-ийн ОБХ-ээр батлуулсан. | Төвийн гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангийн 2024 оны төлөвлөгөөнд тодотгол хийж бэлэн байдлыг хангаж ажилласан байна. | Гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед дэмжлэг үзүүлэх баг нь 2024 онд нийт 10 ажил төлөвлөн 91%-ийн биелэлттэй байна. Хэрэгжүүлсэн ажлууд:<br>- БЗД-ийн “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх гал унтраах дадлага сургалтад 4 хүний бүрэлдэхүүнтэй хамрагдсан”<br>- Галын хорны хэвийн ажиллагааг шалгаж сар бүр тэмдэглэл хөтөлж баримтжуулдаг<br>- Гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах, нөөц бүрдүүлэх зорилгоор 2024.03 сард “Оюу Толгой” ХХК, 2024 онд 09 сард Дархан Уул аймаг дахь их, дээд сургуулийн консорциумтай хамтран алсын явуулыг 2 удаа амжилттай зохион байгуулсан.<br>- Гамшгийн Улсын нөөцийн ХШС-ийн нөхөн сэлгэлтийг II, IV улирлад хийж, Улсын нөөцийг бүрдүүлж ажилласан байна.<br>- Төвийн үйл ажиллагааны хэрэглэгдэх багаж хэрэгсэл, яаралтай тусламжийн эм тарианы нөөцийг сар бүр гарган нэгтгэж, нөхөн хангалтыг хийдэг, 2024 онд 472,515 төгрөгийн яаралтай тусламж эм тариа, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | багаж хэрэгслийн нөхөн хангалтыг зохион байгуулсан. -2025 онд 4,600,000 төгрөгийн тоног төхөөрөмж авахаар төлөвлөж байна. Гамшгийн бэлэн байдлыг хангах төлөвлөгөөний тодотголыг хийсэн. Үерийн гамшиг, объектын түймэр, газар хөдлөлтийн гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг нэмэлтээр боловсруулсан тодотгосон. Галын аюулгүй байдал, гал унтраах дадлага сургуулилтыг Баянзүрх дүүргийн онцгой байдлын хэлтэстэй хамтран зохион байгуулж, гал унтраах бөмбөгөн хорыг үйлчлүүлэгчийн хэсэг, давхруудын коридорт байрлуулсан. | |
| 29 | Цус, цусан бүтээгдэхүүний Улсын нөөцийн хадгалалтын аюулгүй байдлыг хангаж, нөхөн сэлгэлтийг хийнэ. | - | ОБЕГ-тай хийгдсэн гэрээ, ажлын тайлан | Гэрээг дүгнэж, улсын нөөцөд бараа, материал худалдан авах нэмэлт гэрээ байгуулсан. | Гэрээний үүргийг хэрэгжүүлж, сийвэнгийн бүтээгдэхүүний нөхөн сэлгэлтийг бүрэн хийсэн байна. | Улсын нөөцийн хөлдөөсөн шинэ сийвэнгийн нөхөн хангалтыг 3, 4, 10, 11 сард хийж, Улсын нөөцийн цус цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлж ажилласан. Төвийн нөөцийн ХШС, КС-ийн нөхөн хангалтыг сар бүр хийсэн. Цус цусан бүтээгдэхүүний хадгалалтад тогтмол хяналт тавьж ажилладаг. ОБЕГ-тай гэрээг сунгаж баталгаажуулсан. | 100% |
| **Зорилт 2.1.1.** Цусны сонор сэрэмжийн тогтолцооны бүртгэл мэдээллийг баяжуулж, дэмжлэгт хяналт үнэлгээ, мэргэжил арга зүйгээр хангана. | | | | | | | |
| 30 | Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэсэнтэй холбоотой урвал хүндрэлийн мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулна. | - | Үүсгэсэн бүртгэл мэдээллийн сан, хийсэн дүн шинжилгээ | 2023 онд нийт 24 эрүүл мэндийн байгууллагаас мэдээлэл авсан. | Эрүүл мэндийн байгууллагуудын цус, цусан бүтээгдэхүүн сэлбэсэнтэй холбоотой урвал, хүндрэлийн мэдээллийн санг цаасан болон цахим хэлбэрээр үүсгэж, мэдээлэх тогтолцоог сайжруулсан байна. | Эрүүл мэндийн байгууллагуудын цус, цусан бүтээгдэхүүн сэлбэсэнтэй холбоотой урвал, хүндрэлийн бүртгэл мэдээллийн санг цаасан болон цахим хэлбэрээр үүсгэн цахим мэдээний санг урвал хүндрэл илэрсэн өвчтөн болон сэлбэсэн бүтээгдэхүүний мэдээллийг агуулсан байдлаар Excel хэлбэрээр бүртгэн хадгалж байна. 2024 онд цус сэлбэлттэй холбоотой 10 урвал, хүндрэл бүртгэгдэж мэдээний санд хадгалагдсан. Бүтээгдэхүүн захиалга болон олголтын bp.mohs.mn программд ЦЦБ сэлбэсэнтэй холбоотой урвал хүндрэл илэрсэн үед мэдээлэх 3 маягтыг шинээр оруулан туршилтын шатанд явагдаж байна. Үүний үр дүнд цус цусан бүтээгдэхүүн хэрэглэгч эрүүл мэндийн байгууллагууд урвал хүндрэлийг энэхүү программаар мэдээлэх, төвийн хэмжээнд мэдээллийн нэгдсэн сан үүсэх нөхцөл бүрдэж байгаагаар давуу талтай юм. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 31 | Цусны салбар төв болон гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад цусны аюулгүй байдлын дэмжлэгт хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангана. | 5.4 Улсын төсөв<br>- | Дэмжлэгт хяналт үнэлгээний тайлан, зөвлөмж | 2023 онд 3 гэрээт Эрүүл мэндийн байгууллагад дэмжлэгт хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангасан. | Цусны салбар төв болон эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд цахим болон ажлын байран дээрх дэмжлэгт хяналт үнэлгээг тус бүр 3-оос доошгүй удаа хийж, мэргэжил арга зүйгээр хангасан байна. | Цусны аюулгүй байдалтай холбоотой Эрүүл мэндийн сайдын тушаалуудын хэрэгжилтийг сайжруулах,, ЭМС-ын 2018 оны А/506 дугаар тушаалыг шинэчлэхэд шаардлагатай мэдээлэл цуглуулах, эмнэлзүйн зохистой хэрэглээ, зөв дадлыг хэвшүүлэхэд дэмжлэгт хяналт, үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дэмжин туслах зорилгоор Төвийн Ерөнхий захирлын баталсан удирдамжийн дагуу 2024 онд нийт 18 Цусны салбар төв болон эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд цахим болон ажлын байран дээрх дэмжлэгт хяналт үнэлгээ хийж мэргэжил аргазүйгээр хангаж, зөвлөмж хүргүүлэн ажилласан байна. Үүнд:<br>Цахим дэмжлэгт үнэлгээнд: Дархан-Уул, Дундговь, Завхан аймгийн Тосонцэнгэл, Өмнөговь, Сэлэнгэ, Сэлэнгэ аймгийн Мандал, Булган, Дорнод, Баянхонгор, Төв, Хэнтий, Архангай, Завхан, Баян-Өлгий аймгийн цусны салбар төвүүд.<br>Ажлын байран дээрх дэмжлэгт үнэлгээнд: Орхон ЦСТ, Говьсүмбэр ЦСТ, ХУДНЭ тус тус хамрагдсан. 2024 онд дэмжлэгт хяналт үнэлгээг цахим хэлбэрээр хийснээр үйл ажиллагааны чиглэл бүрээр мэргэжил аргазүйн зөвлөгөөг тус төвийн эмч, мэргэжилтнүүдээс шууд авах, бусдаасаа туршлага судлах нөхцөлийг бүрдүүлэх болон цаг хугацаа, зардал хэмнэсэн онцлог, давуу талтай байлаа. Нийслэлийн эрүүл мэндийн газартай хамтран НЭМГ-ын харьяа 14 эрүүл мэндийн байгууллагуудын цусны аюулгүй байдалд дэмжлэгт үнэлгээ хийж мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлсэн. | 100% |
| **Зорилт 2.2.1.** Лавлагаа шатны тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчийн шаардлагад нийцүүлэн өндөр түвшинд үзүүлнэ. | | | | | | | |
| 32 | Цусны бүлэг, хувийн тохирооны Үндэсний чанарын гадаад үнэлгээг зохион байгуулна. | 5.6 Улсын төсөв | Үнэлгээнд оролцсон лабораторийн тоо, тайлан, сургалтад хамруулсан байгууллагын тоо | 2023 оны 6, 11 дүгээр саруудад 2 удаа зохион байгуулж нийт 202 лабораторийг хамруулсан. | 21, 22 дахь удаагийн үндэсний чанарын гадаад үнэлгээг зохион байгуулж, 20, 21 дэх удаагийн үнэлгээний тайлан семинарыг зохион байгуулсан байна. хангалтгүй үр дүнтэй оролцсон лабораториудыг сургалтад хамруулсан байна. | -2024.02.22-нд 20 дах удаагийн гадаад үнэлгээний тайлан семинарыг зохион байгуулж нийт 103 лабораторид гэрчилгээ олгосон. Амжилтгүй оролцсон 2 байгууллагад албан бичиг хүргүүлсэн.<br>-2024 оын 5 сарын 22-нд 21 дэх удаагийн гадаад үнэлгээг зохион байгуулж 103 лабораторийг хамруулаад байна. 2024.09.26-нд 21 дахь удаагийн цусны бүлэг хувийн тохироо тодорхойлох шинжилгээний тайлан семинарыг зохион байгуулж, оролцогч лабораториудад мэдээллийг хүргэсэн.<br>АВО бүлэг тодорхойлох шинжилгээг 100 (94,3%) лаборатори хангалттай хийж хариуг ирүүлж, 6 (5,7%) лаборатори хангалтгүй хариу ирүүлсэн. ·Резус бүлэг-100% зөв хийсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ЧГҮ-ний хөтөлбөрт хамрагдсан нийт лабораторийн 65 (61.3%) нь хувийн тохироо тодорхойлох шинжилгээний хариу ирүүлсэн.<br>Зөв хариу илгээсэн: 40 (61.5%)<br>Буруу хариу илгээсэн:25 (38.5)<br>Хангалтгүй үр дүн үзүүлсэн лабораториудад зөвлөмж хүргэсэн.<br>22 дахь удаагийн үндэсний чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрийг 2024.12.03-ний өдөр зохион байгуулж, 105 лабораторид сорьцыг тараагаад байна. Шинжилгээний үр дүнг хүлээн авах сүүлчийн хугацаа 12 сарын 10. | |
| 33 | Цусны бүлэгнэлтийн шинжилгээний Үндэсний чанарын гадаад үнэлгээг зохион байгуулна. | 8.0 Улсын төсөв Ханган нийлүүлэгч байгууллага | Үнэлгээнд оролцож гэрчилгээ авсан лабораторийн тоо, хангалтгүй үр дүнтэй оролцсон лабораториудад хүргүүлсэн зөвлөмж | 2023 онд 6, 11 дүгээр сард 2 удаа зохион байгуулж, 80%-иас дээш үнэлгээтэй оролцсон лабораториудад гэрчилгээ олгосон. | 6, 7 дах удаагийн үндэсний чанарын гадаад үнэлгээг зохион байгуулж, 5, 6 дах удаагийн үнэлгээний тайлан, семинарыг зохион байгуулж, амжилттай оролцсон лабораториудад гэрчилгээ, хангалтгүй үр дүнтэй оролцсон лабораториудад зөвлөмж хүргүүлсэн байна. | -2024.02.22-нд 5 дах удаагийн тайлан семинарыг зохион байгуулж 80%-с дээш үнэлгээтэй 92 лабораторид гэрчилгээг олгосон.<br>-2024.06.18-нд 6 дахь удаагийн бүлэгнэлтийн шинжилгээний үндэсний чанарын гадаад үнэлгээг зохион байгуулсан.<br>-2024.09.26-нд 6 дахь удаагийн бүлэгнэлтийн шинжилгээний тайлан семинарыг зохион байгуулж, оролцогч лабораториудад мэдээллийг хүргэсэн. Нийт 99 лаборатори оролцсоноос 80%-с дээш үнэлгээтэй 91(92%), 80%-с доош үнэлгээтэй 8(8%) тус тус байсан. Амжилтгүй оролцсон 8 лабораторид зөвлөмжийг хүргүүлсэн.<br>-7 дах удаагийн үндэсний чанарын гадаад үнэлгээг 2024 оны 12 сарын 3-нд зохион байгуулж, 99 лабораторид сорьцыг тараагаад байна. | 100% |
| **Зорилт 2.3.1.** Олон улсын болон үндэсний стандартын шаардлагыг тогтвортой хангаж, тасралтгүй сайжруулна. | | | | | | | |
| 34 | Нэгдсэн менежментийн тогтолцооны стандартыг хэрэгжүүлэн ажиллаж, магадлах аудитад хамрагдана. | 10.0 Улсын төсөв | Магадлах аудитын гэрчилгээ | 2023 онд Нэгдсэн менежментийн тогтолцооны аудит (ISO 9001-ийн 3 дахь давтан баталгаажуулалт, ISO 45001-ийн магадлах аудит)-д хамрагдсан. | Нэгдсэн менежментийн тогтолцооны стандартыг хэрэгжүүлж, магадлах аудитад амжилттай хамрагдсан байна. | Тус төв нь 2016 оноос эхлэн Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 болон Хөдөлмөрийн Эрүүл мэнд аюулгүй байдлын ISO 45001:2018 менежментийн тогтолцооны стандартыг тогтвортой хэрэгжүүлэн, тасралтгүй сайжруулж ажиллаж байна. 2023 оны 11 дүгээр сарын 12,13-ны өдрүүдэд Монсертф ХХК-ий магадлах аудитад амжилттай хамрагдаж, гэрчилгээг үргэлжлүүлэн эзэмших шаардлага бүрэн хангасныг тодорхойлуулсан.<br>Мөн орон нутгийн цусны салбар төвүүдийн үйл ажиллагаанд Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэхэд тасралтгүй дэмжин тусалж, мэргэжил аргазүйгээр ханган ажилладаг бөгөөд 2024 оны 10 сард Дундговь аймгийн ЦСТ Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартын анхдагч | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баталгаажуулалтын аудитад амжилттай хамрагдаж гэрчилгээгээ гардан авсан нь орон нутгийн ЦСТ-ийн анхдагч болсон амжилттай байна. | |
| 35 | Олон улсын ISO стандарт нэвтрүүлсэн "Сайн туршлага" нэвтрүүлэх өдөрлөг зохион байгуулна. | 2.0 Улсын төсөв | Хамрагдсан байгууллага, эмч, мэргэжилтний тоо, ажлын тайлан | 2023 онд энэ чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлээгүй. | Эрүүл мэндийн байгууллагууд, эмч мэргэжилтнүүдэд Олон улсын ISO стандарт нэвтрүүлсэн "Сайн туршлага" нэвтрүүлэх өдөрлөгийг 2 удаа зохион байгуулсан байна. | 1.Дэлхийн чанарын өдөр-Үндэсний чанарын 7 хоногийн хүрээнд" 2024 оны 11 сарыг тусламж үйлчилгээний чанар сайжруулах сар болгон зарлаж донор үйлчлүүлэгч болон ЦЦБ хэрэглэгч эрүүл мэндийн байгууллагуудад чиглэсэн "Үйлчлүүлэгчээ сонсоцгооё" өдөрлөгийг 2024 оны 11 сарын 15, 23-ны өдрүүдэд 2 удаа зохион байгуулсан. Өдөрлөгөөр Төвийн хэмжээнд хэрэгжүүлж ISO стандартын сайн туршлага, лавлагаа шинжилгээний сорьц тээвэрлэхэд болон ЦЦБ-ний захиалга, хадгалалт тээвэрлэлтийн үед анхаарах зүйл болон үйлдвэрлэж буй ЦЦБ-ний танилцуулга, сийвэн гэсгээгч аппаратын танилцуулга, зааварчилгаа, ЦЦБ-ний хэрэглээний мэдээ тайлан гаргахад анхаарах зүйл, Цусны аюулгүй байдлын чиглэлээр хэрэгжүүлж буй Эрүүл мэндийн сайдын тушаалын танилцуулга, г.м агуулгын хүрээнд эмнэлгүүдэд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулагдаж 40 гаруй эмнэлгийн 90 эмнэлгийн мэргэжилтэн оролцсон байна. Мөн өдөрлөгт 200 гаруй донор, үйлчлүүлэгч хамрагдаж уулзалт ярилцлагад хамрагдан санал хүсэлт өгсөн. Энэхүү өдөрлөгт хамрагдсан донор үйлчлүүлэгч болон эрүүл мэндийн байгууллагаас гаргасан саналыг нэгтгэн төвийн чанарын менежмент эрсдэлийн удирдлагын багаар хэлэлцсэн бөгөөд , холбогдох алба тасгууд зарим саналын хүрээнд хэрэгжүүлэх ажлыг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр ажиллаж байна.<br>2. Амгалан амаржих, Налайх эрүүл мэндийн төв, Дундговь цусны салбар төвийн төлөөллүүд манай төвийн ISO стандарт нэвтрүүлсэн сайн туршлагаас суралцаж тус төвийн үйл ажиллагаатай танилцах хүсэлт гарган, сайн туршлагаас судлан, танилцсан.<br>3. 2024.04.27-нд Эрүүл мэндийн лабораторийн мэргэжилтний дэлхийн 7 хоногийг тохиолдуулан MNS ISO 15189:2015-ийг нэвтрүүлсэн сайн туршлага солилцох өдөрлөгийг зохион байгуулж улсын болон хувийн хэвшлийн 85 лабораторийн эмч, мэргэжилтнийг хамруулсан. Өдөрлөгийн хүрээнд:<br>• Лабораторийн үйл ажиллагааны талаар Reel бэлтгэж танилцуулах,<br>• Эрүүл мэндийн лаборатори Чанар ба чадавхад | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тавих шаардлага MNS ISO 15189:2015 стандартын хэрэгжилт, сайн туршлагын танилцуулга хийх,<br>• MNS ISO 15189:2015 стандартын хүрээнд хөтлөгдөж буй баримт бичгийг танилцуулах,<br>• Лабораторийн үйл ажиллагаатай танилцах тур хийх зэрэг үйл ажиллагааг төлөвлөн амжилттай зохион байгуулсан. | |
| 36 | "Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага" MNS 7014:2023 стандартын хэрэгжилтийг хангаж ажиллана. | | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2023 онд Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартын сургалтад 2 ажилтан хамрагдсан. | 2024 онд Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартын шаардлагыг хангах төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласан байна. | Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартын өөрийн үнэлгээ хийж, цаашид сайжруулах 5 чиглэлийн хүрээнд 12 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжилтийг 94,1%-ийн биелэлттэй хангаж ажиллаж байна.<br>Үүнд:<br>1. Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартыг танилцуулах ажлын байран дахь сургалт болон нийт ажилдагсдад чиглэсэн бүлгийн сургалтыг 3 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 121 ажилтан хамрагдсан байна.<br>2. Үйлчилгээний стандартын эрүүл мэндийн ажилтанд тахигдах шаардлага, үйлчлүүлэгчийн харилцааны ерөнхий шаардлага-ыг сайжруулах хүрээнд байгууллагын Соёл хамтач ажиллагааны баг, Төвийн ёс зүйн салбар хороотой хамтран "Сэтгэлээ жолоодож хүндлэлийг түгээе" сарын аяныг зохион байгуулж хэрэгжилт 90%-ийн биелэлтэй байна.<br>3. Төвийн ажиллагсдын эрхэмлэн ажиллах зарчим шинээр батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>4. Хэцүү үйлчлүүлэгчтэй харилцах заавар шинээр боловсруулан ажиллаж байна.<br>5. "Хувь хүний соёл, инээмсэглэл" сэдвээр сургалт хийж нийт 40(61%) ажилтан хамрагдсан.<br>6. Зөөлөн ур чадварын сургагч багшийн сургалтад 3 ажилтан хамрагдаж байна.<br>7. Төвийн ажлын байран дахь хувцаслалтын журамд нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн баталж ажиллагсад мөрдөн ажиллаж байна.<br>8. Тусгай хэрэгцээтэй, хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчид зориулсан гадна талын шат, налуу замыг стандартын дагуу шинэчлэн засварласан.<br>9. Төвийн 1 болон 2 давхарт бүрэн засвар хийж дуугүй хөтчийг шинэчлэн байрлуулж, ажиллагсад үйлчлүүлэгчдэд аюулгүй, таатай орчинг бүрдүүлсэн.<br>10. Төвийн гадна талын хаягжилтыг орох гарах гарц заасан мэдээлэл бүхий болгон шинэчлэж, гэрэлт самбар хэлбэрээр төвийн 1, 2-р байрны гадна талд болон УХТЭ-ийн эмнэлгийн төв хаалганы хэсэгт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байрлуулан хаягжилтын ил тод, ойлгомжтой байдлыг сайжруулсан. Эдгээр ажлыг хэрэгжүүлсний үр дүнд 2024 оны эхний 04 сарын байдлаарх донор, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны дүгнэлтийг 11 сарын байдлаарх дүгнэлтийг харьцуулахад 6.8%-иар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж өссөн үзүүлэлтэй байна. | |
| **Зорилт 3.1.1.** Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангана. | | | | | | | |
| 37 | ЦССҮТ-ийн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг хангана. | 1228.0 Улсын төсөв | Шинэчлэн батлагдсан хөтөлбөр, баталсан тушаал | ЦССҮТ-ийн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр (2021-2025)-ийг баталж, хэрэгжилтийг хангаан ажиллаж байна. | ЦССҮТ-ийн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр (2021-2025)-ийг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Төвийн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр (2024-2026)-ийг шинэчлэн батлуулж 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. Үүнд:<br>- 2024 онд ЭМЯ, ЭМХТ болон бусад холбогдох байгууллагаас зохион байгуулсан сургалт, семинар, зөвлөгөөнд мэргэжлийн дагуу давхардсан тоогоор нийт ажиллагсдын 78 хувь хамрагдсан.<br>- 2 эмч магистрт сурч байгаа бөгөөд мэргэшлийн “Ахлах”, Зөвлөх” зэргийг 2 ажилтан хамгаалсан.<br>- МУ-ын ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын дагуу ур чадварын нэмэгдлийг 25 хүртэлх хувиар 11 удаа, 2019 оны 05 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг улирал бүр 60 хүртэл хувиар урамшуулалт цалин олгосон.<br>- Эрүүл мэндийн яамны харьяа тусгай мэргэжлийн төвүүдийн дунд зохиогдсон спортын 5 төрөлт тэмцээнд байгууллагаараа оролцож 2-р байр эзэлсэн. Хамт олны дунд волейболын нөхөрсөг тэмцээн зохион байгуулж, эрүүл мэнд, хамтын нөхөрлөлийг бүрдүүлсэн.<br>- Нийт ажилтныг урьдчилан сэргийлэх үзлэгт эрт илрүүлэгийн насны ангиллаар 18-30 нас, 31-45 нас, 46-60 насны багц шинжилгээнд хамруулж 45-с дээш болон доош насны бүлэгт хуваах эмэгтэйчүүдийн эмчийн үзлэг, андрологи, урологийн эмчийн үзлэгт нийт 68 ажилтныг /97,1 хувь/ хамруулсан.<br>- Ажилтны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалтыг дэмжиж УХТЭ-ийн цэцэрлэгт тодорхой тооны хүүхдийг хамруулсан. Мөн төвд хүүхдийн өрөө байгуулан, 10 гаруй сая төгрөгөөр тохижуулж ажилтны ажлаа амар тайван хийх нөхцөлийг бүрдүүлсэн.<br>- БЗД-ийн ИТХ-ын ажлын албатай хамтран ажиллаж цусны донорын үйлсийг сурталчлан анх удаа Баянзүрх дүүрэг цусны донор дүүрэг болсон бөгөөд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төвийн 10 ажилтанд газар эзэмших эрхийн бичиг олгосон.<br>- ЭМЯ-ны гэрээний хүрээнд ХХБ-тай гэрээ байгуулан нийт ажилтны 50 гаруй хувь нь ипотек, цалингийн зээлийн бага хүүтэй, түргэн шуурхай үйлчилгээ авч байна. | |
| **Зорилт 3.2.1.** Гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | | | | | | | |
| 38 | Олон улсын цус сэлбэлт судлалын нийгэмлэг, Азийн цус сэлбэлтийн нийгэмлэгтэй хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | 0,4 Улсын төсөв | Санамж бичигт туссан арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Олон улсын цус сэлбэлт судлалын нийгэмлэгийн (ISBT) 2022 оны гишүүнчлэлээ сунгасан. 2019, 2023 онд Азийн цус сэлбэлтийн холбоо (AATM)-той хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. | Олон улсын цус сэлбэлт судлалын нийгэмлэг, Азийн цус сэлбэлтийн нийгэмлэгтэй хамтын ажиллагааг өргөжүүлж, санамж бичигт туссан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна. | - Олон улсын цус сэлбэлт судлалын нийгэмлэгтэй хамтын ажиллагааны гишүүнчлэлийн эрхийг шинэчилсэн.<br>- Азийн цус сэлбэлтийн нийгэмлэгтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд хамтын ажиллагааны санамж бичгийг 5 жилийн хугацаатай шинэчлэн баталсан. AATM-аас 2024 онд нийт 14 ажил хийгдэхээр төлөвлөгдсөн байгаа ба Монгол улсын цусны алба нь хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд нийт 10 ажилд хамтран ажиллахаар санал солилцсон.<br>- Удирдлагын цахим уулзалтыг улирал бүр буюу нийт 3 удаа хийсэн. 2024.05.24/ 2024.07.09 /2024.09.10<br>- AATM-тай хамтарсан webinar сургалт нийт 3 удаа зохион байгуулсан.<br>2024.05.17 Blood safety<br>2024.10.03 AABB certification<br>2024.12.17 Donor vigilance<br>- Азийн цус сэлбэлтийн нийгэмлэгтэй хамтран AABB чанарын хяналтад хамрагдахаар стандартын орчуулгын ажил явагдаж байна. | 100% |
| **Зорилт 3.2.2.** Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлнэ. | | | | | | | |
| 39 | Цусны албаны эрдэм шинжилгээний онол, практикийн XXI бага хурлыг зохион байгуулна. | 6.0 Улсын төсөв | Хэвлэгдсэн илтгэлийн хураангуй | Олон Улсын Эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан, итгэлийн хураангуйг хэвлүүлсэн. | Цусны албаны эрдэм шинжилгээний онол, практикийн XXI хурлыг зохион байгуулж, илтгэлийн хураангуйг хэвлүүлсэн байна. | Цусны албаны эрдэм шинжилгээний онол, практикийн XXI хурлыг "Тусламж үйлчилгээ, цусны аюулгүй байдлыг сайжруулах нь" сэдвийн дор 2024 оны 10 сарын 17-ны өдөр танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулсан. Эрдэм шинжилгээний хуралд нийт 22 илтгэл бүртгэгдсэнээс 4 илтгэл цахим хэлбэрээр, 4 илтгэл ханын хэлбэрээр,12 илтгэл аман хэлбэрээр илтгэсэн. Илтгэлийн хураангуйг хэвлэж тараасан. Хүйтний агглютинины шалтгаант аутоиммуны цус задралын цус багадалтын үеийн бүлгийн зэрүүг судалсан тохиолдлын судалгаа сэдэвт Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч М. Цэрэндэжид нарын хийсэн судалгаа тэргүүн байр, Шинэ үеийн дроныг цус тээвэрлэлтэд нэвтрүүлснээр гарч буй эдийн засгийн үр ашиг сэдэвт Эрдэм | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинжилгээ мэдээлэл технологийн алба Ч. Далайцэрэн нарын судалгаа гутгаар байр, Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн хөлдөөсөн шинэ сийвэнгийн өртөг тооцох нь сэдэвт Үйлдвэрийн тасаг Б.Өнөрцэцэг нарын судалгаа тусгай байр, Цус хандивлагчдын цусны эсрэгбиеийн (а, в) титрийн түвшин, нас, хүйс, биеийн жингийн индексийн хамаарлыг тодорхойлсон үр дүн сэдэвт Нэгдсэн лабораторийн тасгийн эмч А.Оюунтуяа нарын илтгэл тус тус шалгарсан. | |
| 40 | Цус сэлбэлт судлалын салбарын "Үндэсний цахим семинар"-ыг зохион байгуулна. | 3.0 Улсын төсөв | Үндэсний цахим семинарын тайлан | 2023 онд ДЭМБ-ын дэмжлэгээр Үндэсний семинар"-ыг 21 аймгийн 26 Цусны салбар төвийн эмч мэргэжилтнийг оролцуулж танхимын хэлбэрээр зохион байгуулсан. | "Цусны аюулгүй байдлыг сайжруулах нь" сэдэвт Үндэсний семинарыг цахим хэлбэрээр зохион байгуулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна. | "Цусны аюулгүй байдлыг сайжруулах нь" сэдэвт үндэсний зөвлөгөөний хөтөлбөр, төлөвлөгөөг Цус судлалын мэргэжлийн салбар зөвлөлөөр батлуулж 2024 оны 03 дугаар 27, 28-ны өдөр танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулж 21 аймгийн 26 ЦСТ-ийн нийт 77 эмч мэргэжилтэнг хамруулан тус бүрд 2 багц цагийн кредит олгосон. Аймгийн БОЭТ, НЭ-ийн дарга нарт зөвлөмж хэрэгжүүлэх хугацаатай албан бичиг хүргүүлж ажилласан.<br>Уг семинараар Азийн цус сэлбэлтийн холбоо (AATM)-тай хамтран цус сэлбэлт судлалын салбарын цаашдын чиг хандлагын талаар харилцан туршлага солилцохын хажуугаар, улсын хэмжээнд үйл ажиллагаанд мөрдөж буй хууль, журам, зааврын хэрэгжилтийн талаар чиглэл өгч, эмч мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр хангасан. Цусны салбар төвүүдийн үйл ажиллагааны бичмэл тайлан, статистик тайлан, эмнэлзүйн цус сэлбэлтийн зохистой хэрэглээний зарчим, онцлог, давуу тал, цаашид анхаарах зүйлүүдийг онцлон хэлэлцүүлсэн. | 100% |
| **Зорилт 3.3.1.** Сургалт зохион байгуулж, эмч мэргэжилтний мэдлэг, ур чадварыг сайжруулна. | | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 41 | Богино хугацааны багц цагийн сургалт зохион байгуулна. | | Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан эмч мэргэжилтний тоо, тайлан | 2023 онд багц цагийн богино хугацааны сургалтыг үндсэн 2 сэдвээр 18 удаа зохион байгуулж нийт 1452 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. | Богино хугацааны багц цагийн сургалтыг 2-оос доошгүй удаа зохион байгуулж, эмч, эмнэлгийн мэргэжилтэнг мэргэжил арга зүйгээр хангаж, чадавхжуулсан байна. | -"Цусны аюулгүй байдал, зохистой хэрэглээг хэвшүүлье" сэдэвт 2 багц цагийн сургалтын хөтөлбөрийг Цус судлалын мэргэжлийн салбар зөвлөл, ЭМХТ-өөр батлуулан 2024 оны 06 сарын 20-ны өдөр Орхон аймагт зохион байгуулж нийт 57 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>-"Цусны бүлэг, хувийн тохироо тодорхойлох аргачлал" 2 багц цагийн сургалтын хөтөлбөрийг Лабораторийн мэргэжлийн салбар зөвлөл, ЭМХТ-өөр батлуулан 2024 оны 07 дугаар сарын 04-нд Улаанбаатар хотын хэмжээнд зохион байгуулж нийт 30 эмч мэргэжилтнүүд хамрагдсан байна.<br>-Нэгдсэн лабораторийн тасагтай хамтран "Лабораторийн стандартчилал ба үндэсний чанарын гадаад үнэлгээ" сэдэв 1 багц цагийн сургалтад нийт 170 эмч, мэргэжилтнүүд хамрагдан амжилттай зохион байгуулагдсан. | 100% |
| 42 | Авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг төлөвлөн хэрэгжүүлнэ. | - | Зохион байгуулсан сургалт, оролцогчдын тоо, сургалтын бүртгэл, тайлан | Авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, 2023 оны тайланг хугацаанд нь хүргүүлсэн. | Авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Тайланг хугацаанд нь тайлагнасан байна. | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүл мэндийн яамны батлагдсан ерөнхий төлөвлөгөөний хүрээнд Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. Эхний хагас жилийн тайланг 05 дугаар сарын 22-ны өдрийн 181 дүгээр албан бичгээр хугацаанд нь хүргүүлсэн. Зохион байгуулсан сургалтын тоо 1, ажиллагсдын хамрагдалтын хувь 90% байна. Байгууллагын цахим хуудас, фэйсбүүк дэх групп хуудсаар авлигын эсрэг нэгдэе 2 зурагт хуудас,1 бичлэгийг байршуулсан.Хандалтын тоо 430. -Сурталчилгааны самбаруудад зурагт хуудас 8, Youtube суваг, лед дэлгэцээр 2 төрлийн шторк өдөр бүр тэгээсэн. -Нийт ажилтанд Төрийн албан хаагчдын ёс зүйн тухай хуулийг таниулан сурталчлах өдөрлөгийг ёс зүйн салбар хороотой хамтран зохион байгуулж хууль өмгөөлөгч сургалт орсон. Сэтгэлээ жолоодож хүндлэлийг түгээе-2024 аяны хүрээнд Инээмсэглэл хувь хүний хөгжил сэдвээр шинээр томилогдсон эмч сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалт зохион байгуулсан. | 100% |
| 43 | Ажиллагсдын сэтгэлзүйн эрүүл мэндийг дэмжсэн үйл ажиллагаа зохион байгуулна. | 8.0 Улсын төсөв | Зохион байгуулсан арга хэмжээний тайлан, үр дүн | Сэтгэл зүйн чиглэлийн сургалт хийгдсэн. | Гэрээт сэтгэлзүйч ажиллуулж, улирал бүр шаардлагатай арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна. | 1. Ажиллагсдын сэтгэлзүйн эрүүл мэндийг дэмжин "Сэтгэц оношилгоо сэтгэл зүйн төв"-ийн багш, сэтгэл зүйчийг гэрээгээр ажиллуулж байна. Ингэснээр ажиллагсад ажлын байрны стресс, таагүй тохиолдолд орсон үедээ ганцаарчилсан зөвлөгөө зөвлөмж авах бүрэн боломж бүрдсэн.<br>2. Төвийн зүгээс Сэтгэлзүйн булан, Фитнес өрөө, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хөгжлийн бэрхшээлтэй хүний шатыг засварлах, авто машины орц гарцын эргэх булан зэргийг засаж сайжруулсан.<br>3. Байгууллагын соёл, хамтач ажиллагааны багаас дараах ажлуудыг хэрэгжүүлсэн. үүнд:<br>- Төвийн ёс зүйн салбар хороотой хамтран “Сэтгэлээ жолоодож хүндлэлийг түгээе” сарын аяныг зохион байгуулж төлөвлөгөө 90% биелэлттэй<br>- Төвийн ажиллагсдын “**Эрхэмлэн ажиллах зарчим**” шинээр батлуулан “Кофетой уулзалтыг алба тасаг нэгж бүртэй хийж санаа бодлыг сонсож хэрэгжүүлэх ажлыг хийсэн.<br>- **Хэцүү үйлчлүүлэгчтэй харилцах заавар** шинээр батлуулан угтах үйлчилгээ үзүүлдэг хэсгүүдэд байршуулсан.<br>- Угтах үйлчилгээний компьютер дээр толь байршуулж үйлчлүүлэгчийн өмнөөс харж инээмсэглэх орчныг бүрдүүлсэн.<br>- Нийт ажиллагсдад 10.512.500 төгрөгийн 3 төрлийн 8 халаад, 62 хос хувцсыг олгосон.<br>- “Хувь хүний соёл, инээмсэглэл” сэдвээр сургалт хийж нийт 40(61%) ажилтан хамрагдсан.<br>- Зөөлөн ур чадварын сургагч багшийн сургалтад 3 ажилтан сургасан. 2025 онд сургалтуудыг хийхээр төлөвлөсөн. | |
| **Зорилт 3.3.2.** Төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэжлийн болон мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулна. | | | | | | | |
| 44 | Эмнэлзүйн цус сэлбэлт судлал, Цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи чиглэлээр төрөлжсөн мэргэшлийн сургалт зохион байгуулна. | - | Сургалт зохион байгуулах тушаал, сургалтад хамрагдсан суралцагчийн тоо, | Цус сэлбэлт судлалын мэргэшүүлэх сургалтыг 2023 онд 2 удаа зохион байгуулсан. | Эмнэлзүйн цус сэлбэлт судлал, Цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи чиглэлээр төрөлжсөн мэргэшлийн сургалтыг 2 удаа зохион байгуулсан байна. | ЭМ-ийн сайдын 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/284 тушаалаар Эмнэлзүйн цус сэлбэлт судлалаар 4 их эмч, Цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи чиглэлээр 2 Био-Анагаахын мэргэжилтэн хамрагдан амжилттай суралцаж, 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/125 тушаалаар төгссөн. Намрын элсэлтийн Эмнэлзүйн цус сэлбэлт судлалаар 7 их эмч суралцаж байна. | 100% |
| 45 | Цус, цусан бүтээгдэхүүний технологичийн мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулна. | - | Суралцагчдын элсэлт, төгсөлтийн тушаал, хамрагдсан сувилагчийн тоо | Цус сэлбэлт судлалын төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх сургалтыг 2023 онд 2 удаа зохион байгуулсан. | Цус, цусан бүтээгдэхүүний технологичийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг 2 удаа зохион байгуулсан байна. | ЭМХТ-ийн захирлын 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн А/62 дугаар тушаалаар Цус, цусан бүтээгдэхүүний технологичийн мэргэжил дээшлүүлэх сургалтад 6 сувилагч хамрагдан амжилттай суралцаж, ЭМХТ захирлын 2024 оны 8 дугаар сарын 14-ний А/47 тушаалаар амжилттай төгссөн. ЭМХТ-ийн захирлын 2024 оны 10 дугаар сарын 10-ны А/126-р тушаалаар Цус, цусан бүтээгдэхүүний технологичийн мэргэжил дээшлүүлэх сургалтад 11 сувилагч суралцаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 46 | Төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшил болон мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэн батлуулна. | - | Батлагдсан хөтөлбөр | 2020 онд Эмнэлзүйн цус сэлбэлт судлал, цус, цусан бүтэгдэхүүний технологич төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөр батлагдсан. 2017 онд Цус, цусан бүтээгдэхүүний технологич сувилагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр батлагдсан. | Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийг шинэчлэн батлуулж, сургалт эрхэлсэн байна. | Эмнэлзүйн цус сэлбэлт судлал, цус, цусан бүтэгдэхүүний технологич төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөр, Цус, цусан бүтээгдэхүүний технологич сувилагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрүүдийг шинэчлэн боловсруулж удирдлагын зөвлөлд танилцуулсан. Зөвлөмжийн дагуу сайжруулалт хийж ЭМХТ-д хүргүүлсэн. Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/774 тушаалаар төгсөлтийн дараах сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулах, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах шаардлагын дагуу хөтөлбөрийг шинэчилсэн. Сургалтын хөтөлбөрийн үнэлгээнд олон улсад мөрдөгддөг 360 хэмийн үнэлгээ буюу хандлагыг үнэлэх, Mini-CEX буюу мэдлэг үнэлэх, DOPS буюу гардан үйлдлийг үнэлэх аргуудыг оруулж өгснөөр арга зүй, үнэлгээний хувьд шинэчлэгдэж, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг, чадварыг хослуулан чадамжтай мэргэжилтэн бэлтгэх нөхцөл бий болгохыг зорьж байгаараа онцлог. | 100% |
| **Зорилт 4.1.1** Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, дотоод хяналтыг сайжруулна. | | | | | | | |
| 47 | Төвийн дүрэм, бүтцийг шинэчлэн батлуулна. | - | Төвийн дүрэм, бүтцийг шинэчлэн баталсан Эрүүл мэндийн сайдын тушаал | 2020 онд батлагдсан дүрэм, бүтцээр үйл ажиллагаа явуулж байна. | Эрүүл мэндийн сайдаар Төвийн бүтэц, дүрмийг шинэчлэн батлуулж, мөрдсөн байна. | Төвийн нийт алба, тасаг, ажиллагсдын саналыг тусган төвийн дүрэм, бүтцийн шинэчлэлийн төслийг боловсруулж Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн зөвлөмж шийдвэрийн дагуу сайжруулалт хийсэн. Төвийн дүрэм, бүтцийн төслийн танилцуулга, албан бичгийн хамт Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлэхэд бэлэн болсон. | 90% |
| 48 | Дотоод хяналтын нэгдсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | - | Төлөвлөгөө, зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | Дотоод аудитын нэгдсэн төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 100% | Дотоод хяналтын нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж, зөвлөмжийн хэрэгжилтийг хангасан байна. | 2024 онд төвийн дотоод үйл ажиллагаа болон гүйцэтгэлийн хяналт шинжилгээ үнэлгээний хүрээнд 6 зорилт 25 үйл ажиллагаа төлөвлөснөөс 12 сарын 10-ны байдлаар **92%** гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Үүнд:<br>**Дотоод аудит, хяналтын нэгдсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх чиглэлээр:**<br>3 дотоод аудит, 8 дотоод хяналт, 2 тойрон үзлэг хийхээр төлөвлөн бүрэн хэрэгжүүлсэн. Үүнд:<br>• Дотоод аудит 3, төвийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж байгаа, тогтолцооны ISO 9001:2015, ISO 45001:2018 зэрэг 2 стандарт, үйл ажиллагааны ISO 15189:2015 стандартад дотоод аудит хийгдэж тайланг албаны тэмдэглэлээр холбогдох тасаг, албанд хүргүүлсэн. 1 жижиг үл тохирол нийт 20 сайжруулах зөвлөмж гарсан 2024 онд багтаан сайжруулах зүйлс бүрэн биелэлттэй байна.<br>• Дотоод хяналтыг Шилэн данс, Төрийн | 92% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, Мэдээллийн ил тод байдал, Шатахууны зарцуулалт, ЭМ-ийн сайдын тушаал, НМТ-ны журмын хэрэгжилт, БЗЦЦТ, СБ ЦЦТ, Цус цуглуулах үйл ажиллагаа зэрэг нийт 8 удаа хийж 94 зөвлөмж өгснөөс эхний 7 хяналтын зөвлөмжийн хэрэгжилт бүрэн 12 сарын хяналтын 16 зөвлөмж хүлээгдэж байна зөвлөмжийн хэрэгжилт 12 сарын 7-ны байдлаар **83%**-тай байна.<br>• Удирдлагын тойрон үзлэг 5 болон 11 сард нийт 2 удаа тус тус хийж тайланг, сайжруулах 17 зөвлөмжийг албаны тэмдэглэлээр хүргүүлэн хэрэгжилтийг хянаж ажиллаа.<br>• 2024 оны эхний 10 сарын байдлаар хөндлөнгийн аудит санхүүгийн чиглэлээр 2 удаа орсон зөвлөмжийг тус тус СБА-д хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна.<br>**Хуулийн хэрэгжилтийн талаар:**<br>Худалдан авах гэрээ 19, Тендер шалгаруулалтын гэрээ 13, нэмэгдэл 3, Ажил үйлчилгээний гэрээ 13, ЦЦБ нийлүүлэх 77 гэрээ нийт 125 гэрээ байгуулагдсан. Эдгээр гэрээг нийт 29 компанитай байгуулсан ба үүнээс эм, эмнэгийн хэрэгсэл ханган нийлүүлэгч байгууллагуудаас 9 компанитай хамтран ажиллаж байна. 2024 оны 11 сарын 30-ны байдлаар зардлын гүйцэтгэл **104%**-тай байна. Ханган нийлүүлэлтийн гэрээ дуусаагүй тул одоогоор 5 компанитай гэрээг дүгнэсэн байна.<br>Худалдан авах ажиллагааны сургалтад 4 ажилтан хамрагдаж 100% А3 гэрчилгээтэй авсан.<br>2024 оны 02 сард Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдаж 25 дутагдал арилгуулах чиглэл ирсний дагуу заалт бүрээр үйл ажиллагааг бүрэн сайжруулан тайланг заасан хугацаанд хүргүүлсэн.<br>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд 1 удаа үнэлгээ хийж 1 улирлын байдлаар хэмнэлт 25% буюу хангалттай гэж үзсэн. сайжруулах 1 санал буюу худалдан авах үйл ажиллагаа болон цаашид энэ хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах 1 зөвлөмж өгсөн байна.<br>Шилэн дансны хэрэгжилтэд 1-р улиралд дотоод аудитор, 2-р улиралд ЭМЯ-аас тус тус 1 удаа хийгдэн дотоод аудитор 3, ЭМЯ-аас 8 зөвлөмжийг СБА-д хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Мэдээллийн ил тод байдлыг хангах хуулийн хэрэгжилтэд 4 сард 1 удаа хяналт хийн 4 зөвлөмж өгсөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Төвийн хэмжээнд мөрдөж буй журмын хэрэгжилтэд ЦЧАБА 10 сард хийн журмыг 2017, 2020 оноос хойш шинэчлээгүй тул ялангуяа ерөнхий журмуудыг хянаж, ХЭМАБ, ЧМТ-ны ижил журмуудыг нэгтгэх төлөвлөгөө гарган шинэчлэх зөвлөмж хүргүүлэн 12 сарын 5-ны байдлаар 2 журам шинэчлэгдээд 3 журам хэлэлцүүлэгт байна.<br>**Байгууллагын үндсэн үйл ажиллагаа, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар:**<br>ЭМ-ийн сайдын албан даалгаврын хэрэгжилтийн тайланг ЗМА хариуцан тухай бүр бүрэн гаргаж цаг хугацаанд нь илгээсэн.<br>ТҮ-ний чанарын үзүүлэлтийн тайланг ЦЧАБ-ын алба улирал бүр нэгтгэж үр дүнд үнэлгээ хийсэн. УДШ-ээр хэлэлцүүлсэн болно. Мэдээллийн ил тод байдлын үнэлгээг ЭШМТ алба хариуцан 2023 оны хүрсэн түвшин **99%**-д барьж ажилласан<br>Төрийн албан хаагчийн сургалт нийгмийн баталгааг хангах чиглэлээр 3 зорилт 23 үйл ажиллагаа төлөвлөн хөтөлбөрийн хэрэгжилт **100 %** байна.<br>Төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд хагас бүтэн жилээр 2 удаа хяналт үнэлгээ хийсэн байна.<br>**Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр:**<br>Төвд ХЭМАБ-ын орон тооны бус зөвлөл ажилладаг. 2024 онд 11 үйл ажиллагаа төлөвлөсөн 11 сарын 25-ны байдлаар гүйцэтгэл **90%**-тай байна. Хүлээгдэж байгаа ажлууд ажилтны хувцаслалтын журам, гэрээгээр ажил гүйцэтгүүлэгчид сургалт зохион байгуулах, ХХХ-ийн дутууг гүйцээх зэрэг хэрэгжих бүрэн боломжтой ажлууд байна.<br>Төвийн халдвар судлаач эмчээр ахлуулсан ХСХ орон тооны бус баг ажилладаг. 2024 онд 4 зорилт 17 үйл ажиллагаа төлөвлесөн 11 сарын 25-ны байдлаар хэрэгжилт **96,5%** байна. | |
| 49 | Сувилагч мэргэжилтний цогц чадамжид нийцүүлэн төвийн сувилахуйн тусламж үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлнэ. | - | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Сувилахуйн албаны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 16 арга хэмжээ төлөвлөн 98,2% биелсэн. | Сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | Сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр 10 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлсэн. Хэрэгжилтийн хувь 100%. Үүнд:<br>1. Хамтын ажиллагаа:<br>- ЭМХТ, Жайка олон улсын байгууллагатай хамран 3 сувилагчийг шинэ сувилагчийн хөтөлбөр боловсруулах сургалтад хамруулсан<br>- “Эмнэлзүйн сургагч багш” бэлтгэх сургалтад 2 удаа чиглүүлэгч багшаар оролцсон<br>- Монголын сувилагчдын нийгэмлэг, ХБНГУ-тай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамран "Халдварын сэргийлэлт хяналтын сувилагч " бэлтгэх сургалтыг 3 жил дараалан зохион байгуулж 4 сувилагч тусгай мэргэжилтэн бэлдсэн.<br>2.Сувилахуйн тусламж үйлчилгээ<br>- СТҮ-тэй холбоотой гарсан ЭМ-ийн сайдын тушаал дүрэм чиг үүрэг батлах тухай А/424, Сувилагч мэргэжилтний цогц чадамж А/451, Шинэ сувилагчийн хөтөлбөр зэргийг танилцуулсан.<br>- ОУСӨ-ийн арга хэмжээ "Сувилагч танаараа бахархъя", "Сувилагчийн манлайлалд бидний оролцоо" ажил мэргэжлийн уралдаан, Үйлчилгээний стандартад сувилагчийн манлайлал зэрэг үйл ажиллагаанд оролцсон<br>- Дэмжлэгт хяналт үнэлгээг 3 удаа хийж 10 ажил сайжруулах зөвлөмжийг хэрэгжүүлсэн.<br>- ИМҮ-г ДЗБТ, НЛТ, СҮА-ны 30 сувилагч тусгай мэргэжилтэн, 6 үйлчлэгч хамрагдаж үр дүнг үнэлсэн.<br>- ЦЧАБА-тай хамтран ЦЦБ хэрэглэгч ЭМБ-уудын Сувилахуйн албаны аргазүйч нарыг хамруулсан "Үйлчлүүлэгчээ сонсъё" өдөрлөг зохион байгуулж 46 төлөөлөл хамрагдсан.<br>- ЧДЭМТ-ийн 25 сувилагчид цусны аюулгүй байдал, ЦЦБ захиалах, хадгалалт, тээвэрлэлт сэдвээр сургалт хийсэн.<br>- Давхардсан тоогоор 25 сувилагч тусгай мэргэжилтэн тасралтгүй сургалтад хамруулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 50 | Халдварын сэргийлэлт хяналтын сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ. | 21,7 Улсын төсөв | Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 2023 онд 3 зорилтын хүрээнд 15 арга хэмжээ төлөвлөн 98,6% хэрэгжүүлсэн. Эмнэлгийн, тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар гараагүй. | Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжиж, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар гараагүй байна. | 2024 онд халдварын сэргийлэлт хяналтын баг нь гурван зорилтын хүрээнд 18 ажлыг хийхээр төлөвлөж, 100% хэрэгжүүлсэн. Халдварын сэргийлэлт хяналтын орон тооны бус багийн гишүүд болон ажилтны эрүүл мэнд хариуцсан эмчийг шинэчлэн томилуулсан. 6 байгууллагатай гэрээ байгуулан халдварын сэргийлэлт хяналтад шаардлагатай бараа, материалыг нөөцийг бүрдүүлсэн. Сүхбаатар цус цуглуулах төв дээр 2 удаагийн халдваргүйтгэл, шавжгүйтгэлийг зохион байгуулсан. ХСХ-ын 2024 оны сургалтын төлөвлөгөөний дагуу ажлын байрны дадлага сургалтад 27 ажилтанг хамруулсан. Аюултай хог хаягдлын мэдээ болон хатгалтын мэдээг эхний 11-н сараар гарган ХӨСҮТ-ийн тандалтын албанд мэдээлсэн. Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу 7 төрлийн хяналтын хуудсаар нийт 24 удаа хяналт үнэлгээ хийсэн. Шинээр ажилд орсон болон хүүхэд асрах чөлөөнөөс эргэн ажилдаа орсон 10, гэрээт үйлчилгээ үзүүлж буй 3 ажилтан нийт 13 ажилтанг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, МТСА-ын шинжилгээнд хамруулж, чиглүүлэх сургалтад хамруулсан. Урьдчилан сэргийлэх үзлэгт 68 (97.1%) ажилтанг эрт илрүүлгийн насны ангилал 18-30 нас, 31-45 нас, 45-60 насны ангилалаар оруулж 45-аас доош, дээш эрэгтэй эмэгтэй гэж ангилан эмэгтэйчүүд, урологийн эмчийн үзлэгт хамруулсан. | 100% |
| **Зорилт 4.1.2.** Мэдээ тайлан гаргах, нэгтгэх, дүн шинжилгээ хийнэ. | | | | | | | |
| 51 | Тогтмол гаргадаг статистик үзүүлэлт, тоон мэдээ, тайланд дүн шинжилгээ хийж холбогдох албан тушаалтан, байгууллагыг мэдээллээр хангана. | - | Үндсэн үйл ажиллагааны өдөр тутмын тоон мэдээ, сарын статистик үзүүлэлт, тайлан | Сар бүр статистик үзүүлэлт гаргаж дүн шинжилгээ хийж танилцуулдаг. Өдөр тутам үндсэн үйл ажиллагааны тоон мэдээ гаргаж мэдээлдэг. | Тогтмол гардаг статистик үзүүлэлт, тоон мэдээ, тайланд дүн шинжилгээ хийж холбогдох албан тушаалтан, байгууллагыг мэдээллээр хангаж ажилласан байна. | -Цусны салбар төвүүдээс батлагдсан маягтаар 2023 оны үйл ажиллагааны тайланг хүлээн авч нэгтгэн, дүн шинжилгээ хийж, ЭМХТ-д тайлангийн хугацаанд хүргүүлсэн. ХДХВ/ДОХ/БЗДХ-ын төв, кабинетын үйл ажиллагааны тайланг гарган ХӨСҮТ-д хугацаанд нь мэдээлсэн. Нийслэлийн статистикийн газарт сар бүрийн 4-ний дотор төвийн ЦЦБ үйлдвэрлэл болон борлуулалтын тайланг гарган нийт 12 удаа мэдээлсэн.<br>-Цусны албаны сүүлийн 5 жилийн үндсэн үзүүлэлтийг нэгтгэн баяжуулж "Эрүүл мэндийн үзүүлэлт 2023" эмхэтгэлд 2023 оны онцлох үйл ажиллагааны хамт хэвлүүлсэн. Цусны албаны үндэсний семинарт тайлан мэдээ гаргалт, сайжруулах зөвлөгөөг танилцуулж мэргэжил арга зүйгээр хангасан.<br>-Цусны албаны үйл ажиллагааны статистик үзүүлэлтийн 2013-2023 оны дэлгэрэнгүй нэгтгэл гаргаж, мэдээний бүртгэлийн санг баяжуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2024 онд сарын бүрийн статистик мэдээг12 удаа гарган, дүн шинжилгээ хийж, ажиллагсад болон удирдлагыг мэдээллээр тогтмол хангасан. Өдөр тутмын статистик тоон мэдээ гаргаж төвийн дотоод группэд байршуулж мэдээллийн шуурхай ил тод байдлыг хангаж, шийдвэр гаргах боломжоор хангасан. | |
| 52 | 2023 оны үйл ажиллагааны тайлан, статистик үзүүлэлтийн эргэн мэдээллийн эмхэтгэл гаргана. | - | Бэлтгэж гаргасан эмхэтгэл, тараасан тоо | ЭМХТ-ийн статистик үзүүлэлтийн эмхэтгэлд мэдээлэл оруулдаг. | 2023 оны үйл ажиллагааны тайлан, статистик үзүүлэлтийн эргэн мэдээлэл бэлтгэж, мэдээллээр хангасан байна. | Азийн өндөр хөгжилтэй орнуудын цусны албаны сайн туршлагаар "Цусны алба 2023" сэдэвт сүүлийн 10 жилийн үндсэн үйл ажиллагааны мэдээлэл, ирээдүйн чиг хандлага, түүхэн товчоо болон нэвтрүүлсэн шинэ технологийг 10 бүлэг болгон эмхэтгэж, монгол, англи хэлээр хэвлүүлсэн. Цусны алба 2023 эмхэтгэл нь орон нутгийн ЭМ-ийн байгууллагын удирдлага, цусны салбар төвийн эмч мэргэжилтэн, судлаачид болон шийдвэр гаргагчид баталгаажсан мэдээлэл нэг дороос авах, баримтжуулан үлдээж үргэлжлүүлэн баяжуулж явах эх суурийг тавьснаараа онцлог ач холбогдолтой юм. | 100% |
| **Зорилт 4.1.3.** Төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийг сайжруулж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 53 | Санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ. | - | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь, аудитын дүгнэлт | 2022 оны аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан. | Төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, зөрчилгүй дүгнэлт авсан байна. | 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар "Өөрчлөлтгүй" санал дүгнэлтийг авсан. Аудитын байгууллагаас өгсөн 3 зөвлөмж, 4 албан шаардлагыг биелүүлэх төлөвлөгөө гаргаж ажиллаж, биелэлтийг Үндэсний аудитын газарт тайлагнасан. Шилэн дансны цахим систем болон Үндэсний аудитын газрын fas.gov.mn цахим системд оруулсан нь хяналтын шатанд явж байна. Санхүү, бүртгэлийн алба 2024 онд 24 заалт бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар төлөвлөгөөний биелэлт 89,7 хувьтай байна. Тус төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлээрээ өртгөө нөхөж "0 үлдэгдэлтэй болсон үндсэн хөрөнгийн жагсаалтыг гаргаж байгууллагын ӨХБЗ-өөр хэлэлцүүлэн цаашид ашиглах боломжтой хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнэлгээг тогтоолгох, ашиглах боломжгүй хөрөнгийг актлуулах ажлыг зохион байгуулаа. Ахмад настны тухай хуулийн 14.6, 14.7, МУ-ын Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавих" үйл ажиллагааны журмыг батлуулж, Төрийн санд нээлгэх хүсэлтийг ЭМЯ, СЯ-нд гаргасан, шийдвэрлүүлэх түвшинд явж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 4.1.4.** Байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай техник, тоног, төхөөрөмжийн шалгалт тохируулга баталгаажилтыг тогтмол хийлгэнэ. | | | | | | | |
| 54 | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт, тохируулга, баталгаажуулалтыг хийлгэж, хэвийн үйл ажиллагааг хангана. | 19.7 Улсын төсөв | -Шалгалт тохируулга, баталгаажуулалтын гэрчилгээ -Засвар үйлчилгээний төлөвлөгөө, хэрэгжилтийн хувь | 2023 онд тоног төхөөрөмжийн баталгаажуулалт 8, багаж хэрэгслийн шалгалт тохируулга 57 удаа хийлгэсэн. Эмнэлгийн тоног төхөөрөмжид 7 удаагийн төлөвлөгөөт засвар үйлчилгээ хийсэн. | Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалтыг бүрэн хийлгэж гэрчилгээ авсан байна. Тоног төхөөрөмжийн төлөвлөгөөт болон өдөр тутмын засвар үйлчилгээг хийж төвийн үндсэн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангасан байна. | Холбогдох тушаал, журмын дагуу жилийн эцсийн байдлаар электрон Жин-1, дусаагуур-11 даралтын аппарат-5 электрон жин-35 нийт 52 ширхэг хэмжих хэрэгслийг мэргэжлийн байгууллагаар шалгалт тохируулга, баталгаажуулалт хийлгэж гэрчилгээжүүлсэн. Эмнэлгийн тоног төхөөрөмжид 9 удаагийн төлөвлөгөөт засвар үйлчилгээ хийсэн. Тоног төхөөрөмжийн өдөр тутмын засвар, үзлэг үйлчилгээг цаг тухай бүр хийж нийт 32 удаагийн дуудлагын дагуу төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг сар болгон үзлэг, засвар үйлчилгээ хийж техникийн ашиглалтын паспортод тэмдэглэл хөтөлж хэвийн үйл ажиллагааг хангаж, төлөвлөгөөний биелэлт 100% хэрэгжсэн. | 100% |

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ НЭГТГЭЖ ХЯНАСАН:

ЗАХИРГАА МАРКЕТИНГИЙН АЛБАНЫ ДАРГА Ч.БАТБОЛД